

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 07 дугаар сарын 03-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-9
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	10-60
1. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/	10-25
2. Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо болон Хүний эрхийн Үндэсний Комиссын 2026 оны төсвийн төслийн талаар хэлэлцэх, үргэлжлэл	25-53
3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 06 дугаар дүгнэлт /Эд хөрөнгийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/	53-58
4. Хуулийн хэсэг, зүйл, заалт нь өөр хоорондоо эсхүл бусад хуультай зөрчилдсөн талаарх хууль зүйн дүгнэлт	58-60

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 07 дугаар сарын 03-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 38 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Цогтбаатар;

Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Л.Мөнхбаатар;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, Х.Баттулга, С.Эрдэнэболд.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлэв.

Нэг.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын зөвлөх И.Баттөгс, Улсын ерөнхий прокорын туслах, Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Ц.Батболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны

ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, мөн албаны референт Л.Хурцбилэг нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Нэг.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, Л.Соронзонболд нарын тавьсан асуултад Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 2, 3, 4, 5, 6, 7 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хамт өргөн мэдүүлсэн:

Хоёр.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн тавьсан асуултад Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 3, 4 дүгээр зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гурав.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав

О.Номинчимэг: 1.Төслийн 2 дугаар зүйлийн “7.5 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн “албан тушаалтан” гэсний дараа “зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн оршин суугаа /оршин байгаа/ газар, эсхүл тухайн зөрчил үйлдэгдсэн нутаг

дэвсгэрийн” гэж,” гэснийг “7.5 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн “харьяалах шүүхэд хүсэлт гаргана. ” гэснийг “харьяаллын дагуу зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн оршин суугаа /оршин байгаа/ газар, эсхүл тухайн зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн шүүхэд хүсэлт гаргана.” гэж,” гэж өөрчилж 4 дүгээр зүйлд шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	3
Бүгд:	14

78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Б.Пүрэвдорж, Г.Уянгахишиг нарын тавьсан асуултад Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Улсын ерөнхий прокурорын туслах, Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Ц.Батболд нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, Д.Ганбат нарын тавьсан асуултад Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Улсын ерөнхий прокурорын туслах, Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Ц.Батболд нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

О.Номинчимэг: 2.Төслийн 4 дүгээр зүйлийн “мөн зүйлийн 6.8 дахь заалтын “7.6 дугаар зүйлийн 9 дэх хэсэг, 7.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэг,” гэснийг “7.1 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 7.6 дугаар зүйл, 7.7 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 7.9 дүгээр зүйл, 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6,7 дахь хэсэг, 7.11, 7.12, 7.15, 7.17 дугаар зүйл,” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	2
Бүгд:	15

86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг саналаа тайлбарлаж үг хэлэв.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо болон Хүний эрхийн Үндэсний Комиссын 2026 оны төсвийн төслийн

талаар хэлэлцэх, үргэлжлэл

2.1. Улсын дээд шүүхийн 2026 оны төсвийн төслийн талаар хэлэлцэх

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, мөн шүүхийн ерөнхий нягтлан бодогч А.Эрдэнэцэцэг, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Улсын дээд шүүхийн 2026 оны төсвийн төслийн урсгал зардал болон хөрөнгө оруулалтын зардалтай холбогдуулан үг хэлэхээр үргэлжлэв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Б.Энхбаяр нар үг хэлэв.

О.Номинчимэг: Улсын Дээд шүүхийн 2026 оны төсвийн саналыг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг тусган улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр хянасныг Улсын дээд шүүхийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	6
Бүгд:	15

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.2. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2026 оны төсвийн төслийн талаар хэлэлцэх

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, мөн зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга, Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга С.Наранбилэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2026 оны төсвийн төслийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг танилцуулав.

Төсвийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Л.Соронзонболд, П.Сайнзориг, Д.Ганбат нарын тавьсан асуултад Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Х.Тэмүүжин нар үг хэлэв.

О.Номинчимэг: Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2026 оны төсвийн саналыг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг тусган улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр хянасныг Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.3.Шүүхийн сахилгын хорооны 2026 оны төсвийн төслийн талаар хэлэлцэх

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн сахилгын хорооны дарга Д.Ариунтуяа, мөн хорооны Ажлын албаны дарга Д.Мөнхзориг, Шүүхийн сахилгын хорооны Санхүү, төсөв, хөрөнгө оруулалт хариуцсан ахлах референт, ерөнхий нягтлан бодогч Б.Ариунжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Шүүхийн сахилгын хорооны 2026 оны төсвийн төслийг Шүүхийн сахилгын хорооны дарга Д.Ариунтуяа танилцуулав.

Төсвийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Д.Ганбат нарын тавьсан асуултад Шүүхийн сахилгын хорооны дарга Д.Ариунтуяа, хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд үг хэлээгүй болно.

О.Номинчимэг: Шүүхийн сахилгын хорооны 2026 оны төсвийн саналыг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг тусган улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр хянасныг Шүүхийн сахилгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5

Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.4.Хүний эрхийн Үндэсний Комиссын 2026 оны төсвийн төслийн талаар хэлэлцэх

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн Комиссын Тамгын газрын дарга Ц.Адъяахишиг, Хүний эрхийн Үндэсний Комиссын Санхүү, хөрөнгө оруулалтын тасгийн дарга, ерөнхий нягтлан бодогч Б.Бадамсэрээжид нар оролцов.

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2026 оны төсвийн төслийг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид танилцуулав.

Төсвийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, С.Одонтуяа, Б.Энхбаяр нарын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Х.Тэмүүжин нар үг хэлэв.

О.Номинчимэг: Хүний эрхийн Үндэсний Комиссын 2026 оны төсвийн саналыг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг тусган улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр хянасныг Хүний эрхийн Үндэсний Комиссын төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 12 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 06 дугаар дүгнэлт /Эд хөрөнгийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 06 дугаар дүгнэлтээс Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Д.Ганбат нарын тавьсан асуултад итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал хариулж,

тайлбар хийв.

О.Номинчимэг: 1.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 9.1.3, 9.1.4-т заасан үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн үнээс бууруулж бүртгэхгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 9.1.3, 9.1.4-т заасан үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн үнээс бууруулж бүртгэхгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 9.1.3, 9.1.4-т заасан үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн үнээс бууруулж бүртгэхгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “... үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, ... өмчлөх ... эрхтэй. ...” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Хуулийн хэсэг, зүйл, заалт нь өөр хоорондоо эсхүл бусад хуультай зөрчилдсөн талаарх хууль зүйн дүгнэлт

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх С.Энхцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, мөн албаны референт Л.Хурцбилэг нар байлцав.

Улсын Их Хурлын Тамгын газраас гаргасан Хууль зүйн дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур танилцуулав.

Хууль зүйн дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

О.Номинчимэг: 1.Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь өөр хоорондоо эсхүл бусад хуультай зөрчилдсөн талаарх Улсын Их Хурлын Тамгын газрын 2025 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 2025-10 тоот хууль зүйн дүгнэлтийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Тав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, мөн албаны референт Л.Хурцбилэг нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

О.Номинчимэг: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 47 минут үргэлжилж, 22 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 72.7 хувийн ирцтэйгээр 12 цаг 25 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 07 дугаар сарын 03-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим 10 цаг 45 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

О.Номинчимэг: Хууль зүйн байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая аа. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Ирцэнд орсон Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн, Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн, Одсүрэнгийн Номинчимэг, Салдангийн Одонтуяа гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Ухнаагийн Отгонбаяр гишүүн, Пүрэвжавын Сайнзориг гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Гончигдоржийн Уянгахишиг гишүүн, Даваагийн Цогтбаатар гишүүн, Баттөмөрийн Энхбаяр гишүүд ирсэн байна аа. Дамдины Цогтбаатар дарга өнөөдөр гадаадад томилолттой байгаа. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр 4 асуудал хэлэлцэхээр, 5 асуудал хэлэлцүүлэхээр байгаа.

Нэгдүгээрт, нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэнэ ээ. Нийслэлийн энэ хуультай дагалдаж орж ирсэн 3 хуулийг бид хэлэлцэх байгаа.

Хоёрдугаарт, Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Шүүхийн сахилгын хороо болон ХЭҮК-ын 2026 оны төсвийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Гуравдугаарт, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 06 дугаар дүгнэлт буюу Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Дөрөвдүгээрт хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь өөр хоорондоо эсхүл бусад хуультай зөрчилдсөн талаар хууль зүйн дүгнэлтийг сонсож хэлэлцэнэ. Энэ маань одоо Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлж байгаа Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын дэгийн тухай, Хяналтын тухай гээд энэ олон багц хуулиудтай холбоотойгоор Улсын Их Хурлын Тамгын газраас хууль зүйн дүгнэлт гаргасан. Үүнийг сонсоно.

Тавдугаарт бусад гэсэн асуудал байна. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Та яах вэ. Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Бусад асуудлын хүрээнд өчигдрөөс Улсын Их Хуралд суудалтай намын бүлгийн удирдлагууд бас зөвшилцсөн байгаа. Улсын Их Хурлын намын

чуулганы хугацаанд Улсын Их Хуралд суудалтай МАН, АН, ХҮН намын төлөөллүүд оролцоод, гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын бие даасан хуулийн төслийг санаачилж боловсруулж Улсын Их хуралд өргөн барьж хэлэлцье гэдэг асуудлыг бас зөвшилцөж ойлголцсон байгаа.

Тийм учраас Гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтын тухай бие даасан хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулах байнгын хорооноос байгуулж ажиллах асуудлыг хэлэлцье гэсэн ийм саналтай байна.

О.Номинчимэг: Санал горимын санал юм уу. Энхбаяр гишүүн энэ асуудал өчигдөр намын бүлгүүдийн дарга нарын хооронд бас зөвшилцсөн асуудал юм байна шүү дээ тиймээ. Тэгэхээр энэ нөгөө намын бүлгүүд яг яаж зөвшилцсөн ажлын хэсгээ яаж байгуулна гэдэг асуудлыг нь сонсож байгаад энэ асуудлыг шийдье тэгэх үү. Яг нөгөө ямар асуудал бид нар хэлэлцсэнийг нь бас мэдэхгүй байгаа шүү дээ. Бүрэлдэхүүний юу байх юм, ийхийн гээд.

Энхбаяр гишүүний саналыг сонслоо. Бусад гэдэг асуудал дээр бас ийм санал гаргаж байна гэж ойлголоо. Хэлэлцэх асуудлаа баталъя.

Нэгдүгээр асуудал руу оръё. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Засгийн хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсэг ирсэн байна. Энэ бол нэн яаралтай горимоор бас хэлэлцэж байгаа асуудал анхны хэлэлцүүлэг байгаа.

Ажлын хэсэг Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хууль тогтоомж гэрээ эрх зүйн газрын дарга Үнэнбат, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын зөвлөх Баттөгс, Хот байгуулалт барилга орон сууцжуулалтын сайд Бат-Амгалан сайд бас хүрэлцэн ирсэн байна аа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдон хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцууллаа.

Эхний асуудал 1 дүгээр дагалдсан хууль буюу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье ээ.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Байна шүү дээ уучлаарай. Соронзонболд гишүүнээр тасалъя. Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Өглөөний мэнд хүргэе ээ. Яг 1 дүгээр зүйлтэй гэхээсээ илүүтэйгээр ерөнхийдөө энэ түгжрэлийг бууруулах гэдэг агуулгын хүрээнд нэг тодруулж асуумаар зүйл байгаа юм. Одоо бид нар анзаарсан бол яг 1 дүгээр эгнээ таглаж машин зогсох, байршуулах асуудал маш төвөгтэй байгаа. Тэгэхээр энэ дээр

нэг хэсэг нөгөө ачилтын машин гэж нэлээн явсан. Харин одоо энийг яг мэдэхийг хүсээд байгаа юм нь ачилтын машин гэхгүйгээр нэгэнтээ бид нар дүрэм нь торгууль нь тодорхой, дүрмийн зөрчил гэдэг нь тодорхой байгаа нөхцөлд нөгөө гаднынхан шиг шууд тикет бичээд явна гэдэг шиг тэр зарчмыг хэрэгжүүлэх боломж байна уу? Өөрөөр хэлэх юм ер нь цахимжчихсан гэж ойлгоод байгаа шүү дээ. Бүх автомашины бүртгэл, торгуулийн систем тиймээ, тэр бүх юм автоматчихаад байгаа.

Тэгэхээр энэ дээр юу гэдэг юм сайн дурынхан бид нар ковидын үеэр сайн дурынхныг ажиллуулж байсан шүү дээ. Тэрэнтэй төстэй хувилбараар буюу одоо жишээлбэл цагдаагийнхны хүч хүрдэггүй юмаа гэхэд сайн дурынхныг гэрээлээд яг энэ тикет бичдэг ажил мөн түүнчлэн яг энэ зогсоолын төлбөртэй харьцуулахад тэр нь өөрөө юу гэдэг юм торгуулийн хэмжээ бага байгаагаас хамаараад тэнд зүгээр зогсоочихдог асуудал үүсдэг юм уу? Яагаад яг тэнчээ 1 дүгээр эгнээг чөлөөлж чадахгүй байгаад байна. Тэгэхээр тэрний шийдэл нь саяын тикет бичих болон торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх ийм боломжуудыг бид нар энэ удаа зарчмын зөрүүтэй саналаар оруулах боломж байна уу гэдгээ тодруулахын тулд энэ асуултыг асуугаад байгаа юм шүү. Ойлгогдсон уу асуулт нь.

О.Номинчимэг: Ажлын хэсэг хэн хариулах вэ? 3 дугаар микрофон.

М.Үнэнбат: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе ээ. Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. Ер нь сая таны хэлж байгаа яг энэ хүрээндээ олон нийтийн цагдаагийн бид бүхэн ажиллуулж байгаа. Тэгээд олон нийтийн цагдаа энэ зөрчлөө замын цагдаагийн энэ 1 дүгээр эгнээ байрлах дүрэм зөрчиж байгаа зөрчлүүддээ тодорхой хэмжээний зөрчил торгууль оногдуулах энэ эрх нь байж байгаа. Энэ хүрээндээ бид бүхэн арга хэмжээ авч ажиллана.

Хоёрдугаарт юу байна вэ гэхээр саяын энэ Эй Ай хяналтын камерын системтэй холбоотойгоор 10 зөрчлийг бол хяналтын камераар илрүүлээд, энэ хүрээндээ зөрчлийн торгуулийн хуудсыг цахимаар шууд хүргүүлдэг, тэрийг нь эрх бүхий албан тушаалтан цахим гарын үсгээр баталгаажуулдаг энэ зохицуулалтыг Зөрчлийн хуулиудад сая оруулж ирж байгаа. Тэгэхдээ энэ сүүлийн үед иргэдэд яг энэ зөрчилтэй холбоотой хүргэж байгаа торгуулийн мэдээлэл зүгээр анхааруулга байдлаар явж байгаа. Яг энэ хуулийн зохицуулалт хэрэгжээд эхлэхэд 2026 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлээд энэ торгууль яг бүр хуулийн энэ зохицуулалт хэрвээ хууль батлагдвал хэрэгжээд явна аа. Энэ хүрээндээ саяын 1 дүгээр эгнээнд тавьж байгаа энэ машинуудын зөрчилтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх боломж нь байгаа.

Дээрээс нь одоо гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу иргэд энэ зөрчлийн талаар мэдээлдэг ийм зохицуулалт мөн хуульд байгаа. Хэрвээ иргэд мэдээлсэн тохиолдолд тухайн мэдээлсэн гаргасан зөрчлийнх нь тодорхой хэмжээгээр урамшуулдаг ийм хуулийн журам батлагдаад явж байгаа. Энэ хэрвээ гарсан тохиолдолд иргэдийн оролцоо нэлээдгүй нэмэгдэнэ. Ийм зөрчлийг шийдэх ийм бололцоо нь гарна.

Хоёрдугаарт нь юу байна вэ гэхээр сая таны хэлж байгаагаар одоо энэ зорчих хэсгийн хэсэг дээр машин тавиад байгаа асуудлуудыг торгуулийн 1 дүгээрт бол торгуулийн хэмжээг өсгөх, 2 дугаарт эрх хасах хүртэл шийтгэл оногдуулдаг байа аа. Тэгэхгүй бол энэ зам замын байгууламж болон иргэдийн энэ зорчих хэсгийн аюулгүй байдалд нөлөөлөөд байна гэсэн ийм судалгаа, ийм тодорхой тооцоолол гарсан

учраас Нийслэлийн Засаг даргаас бол Хууль зүй, дотоод хэргийн сайдад албан бичиг хүргүүлээд Зөрчлийн хуулийн энэ яг энэ тодорхой төрлийн зөрчлүүдэд энэ саяын таны хэлж байгаа зам, замын байгууламж бол 1 дүгээр эгнээн дээр тавих. Энэ бүтээн байгуулалт тавьсны дараагаар машинууд дээр нь гарч зогсоод зам байгууламж эвдэх ийм зөрчлүүд удаа дараа давтагдаад байгаа. Хэдийгээр бид бүхэн энэ торгуулийн ажлыг ингэж авч байгаа ч гэсэн энэ бол нөгөө иргэд яг тэр зөрчлийг гаргах энэ буурахгүй байгаа учраас энэтэй холбоотой сахилга хариуцлагыг чангатгах үүднээс хэрвээ одоо энэ иргэдийн зорчих хөдөлгөөн дээр хэсэг дээр гаргаж тавиад замын хөдөлгөөн болон иргэдийн аюулгүй байдалд учруулж байгаа бол жолоодох эрхийг хасах хүртэл шийтгэл оногдуулдаг байяа аа. Зөрчлийн хуулийн ийм шийтгэлтэй болгоё гэдэг саналыг Нийслэлийн Засаг даргаас өнгөрсөн 7 хоногт Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлчихсэн байж байгаа.

Тэгэхээр энэ хүрээндээ шийдэгдээд хуулийн төсөл нь намрын чуулганаар бараг орж ирэх болов уу. Яагаад гэхээр Зөрчил зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр ажлын хэсэг гарчихсан ажиллаж байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ хүрээндээ таны хэлж байгаа асуудал шийдэгдээд явна.

О.Номинчимэг: Уянгахишиг гишүүн тодруулъя.

Г.Уянгахишиг: Тэгвэл ямар ч байсан эрх зүйн орчны хүрээнд асуудлууд нь боломжтой. Харин тэр зөрчил шийдэхтэй холбоотой асуудлыг намрын чуулганаар оруулж ирэх юм байна. Тэгэхээр яг одоо бид нар энэ хуулийн төслүүдийг нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэж байх явцад шаардлагатай буюу яг энэ 1 дүгээр эгнээг чөлөөлөхөд нэгдүгээрт мэдээж Зөрчлийн хуулийн тухай асуудал гарч ирж байна. Хоёрдугаарт, олон нийтийн цагдаа ажиллуулахтай холбоотойгоор яг тэр тикет бичих гэдэг энэ асуудлыг зохицуулахад энэ хууль эрх зүйн хүрээнд бас өөрчлөлт орох шаардлага байгаа юу?

О.Номинчимэг: Ажлын хэсэг 3 дугаар микрофон.

М.Үнэнбат: Тэгэхээр яг өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд таны саяын асуудлыг шийдвэрлээд явах бололцоотой гэж харж байгаа нэгд.

Хоёрдугаарт юу байна вэ гэхээр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу хөндөгдөөгүй заалтыг нэмэх боломж байхгүй. Тэгэхдээ өмнө энэ зохицуулж байгаа хуулийн хүрээнд тэр холбогдох журам болон энэ зохион байгуулалтын шинжтэй арга хэмжээг аваад явахад бололцоотой гэж ингэж үзэж байгаа.

О.Номинчимэг: Соронзонболд гишүүн асуулт асууя.

Л.Соронзонболд: Энэ нийтийн тээвэртэй холбоотой ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд ингээд нийслэлд ирж зорчиход орон нутгийн төсвөөс төсөвт төсвөөс авлага үүсээд байна аа. Улаанбаатар хотод өнгөрсөн хугацаанд 1.6 тэрбум төгрөгийн авлага хуримтлагдаад байна. Цаашдаа болохоор аймаг, нийслэлийн аймгуудын төсөв дээр нь тавих тухай орсон байна л даа. Тэгэхээр энэ дээр ерөнхийдөө тухайн орон нутгаас ирж зорчиж байгаа хүнийг ер нь яаж тоолох гэж

байгаа юм. Тэгээд яаж авлагаа үүсгэхээр төлөвлөж байгаа вэ гэдэг нэг асуулт байна.

Дээрээс нь энэ жолоочийн даатгалтай холбоотойгоор ер нь жолоочийн хариуцлагын даатгалын өнөөдрийн хураамжийн хэмжээ маш бага байгаа, гарч байгаа хохиролтойгоо ерөөсөө дүйцэхгүй байгаад байгаа. Тэгэхээр энэ талаар ер нь энэ Жолоочийн даатгалын тухай хуульд оруулж байгаа өөрчлөлт дээр энэ талыг тусгаж байгаа зүйл заалт байгаа юу?

О.Номинчимэг: Ажлын хэсэг 3 дугаар микрофон, Үнэнбат дарга,

М.Үнэнбат: Соронзонболд гишүүний асуултад хариулъя.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний зорчиж байгаа тоо 2019 онд 12.7 сая зорчилт байгаа давхардсан тоогоор. Санхүүжилтийн тухайд 6.4 тэрбум. Тэгээд 2020 онд 10.2 сая зорчилт, 2021 онд 7.6 сая зорчилт, 2022 онд 9.6 сая зорчилт гээд ингээд тухайн үед ковидтой холбоотойгоор энэ зорчилтууд өөр өөр байсан. Өнөөдрийн байдлаар 3.3 сая иргэн нийтийн тээврээр зорчсон гэсэн ийм тоо байгаа. Энэ орж ирж байгаа зохицуулалт юу байна вэ гэхээр Улаанбаатарын харьяалалтай иргэн Говь-Алтай юм уу, Увс аймагт очоод нийтийн тээврээр зорчсон тохиолдолд тухайн зардлыг нь Улаанбаатарын төсвөөс тухайн аймаг руу шилжүүлэх, аль эсвэл тухайн хөдөө орон нутгаас ирсэн иргэн Улаанбаатар хотод нийтийн тээврээр зорчсон тохиолдолд тэр аймгаас нь мөнгийг нь шилжүүлж авах ийм өр авлагын асуудал үүсээд байгаа.

Өнөөдрийн байдлаар 315 сая төгрөгийг энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэн энэ аймгуудаас нийслэлд төлөхөөр ийм өр авлагын асуудал байгаа. Тэгэхээр энэ нөгөө талдаа юу байна вэ гэхээр 2 тийш нь нөгөө тухайн тухайн аймгуудынхаа төсөл дээр шууд тавиад өр авлага үүсгэхгүй бол хэрвээ аймагтаа явсан бол тэр асуудлыг нь тухайн аймаг нь шийдээд л явчихдаг байх юм бол энэ зарчмын хувьд нөгөө аймаг аймаг руу шилжүүлж байгаа асуудал нь тухайн аймаг дээр шийдэгдээд явчихвал аль аль талдаа өр авлагагүй, аудитын дүгнэлт ороход ч гэсэн энэ асуудлыг шийдвэрлэх дөхөмтэй байгаа юм. Тэгэхээр тухайн аймагт бол иргэд хөгжлийн бэрхшээлтэй иргэн тухайн аймагтаа зорчвол тэр аймаг нь нөхөн олговрыг нь ч шийдчихдэг, нийслэлд зорчсон нь нийслэл шийдчихдэг л ийм л байя гэсэн ийм зохицуулалт оруулж ирж байгаа юм.

Хоёрдугаарт энэ жолоочийн хариуцлагын даатгалтай холбоотой хураамжийн тухайд бол өөрчлөлт оруулах зохицуулалт орж ирээгүй. Зүгээр одоо энэ осол аваар гарсан үед хэрвээ осол дээр осолд холбогдсон 2 хүн өөрсдөө тохиролцоод ямар нэгэн өр авлагагүй юу, гомдол саналгүй гэвэл энэ асуудлыгаа цагдаад цахимаар энэ даатгалын байгууллагууд руу асуудлаа явуулаад тэгээд энийг нь шууд шийддэг ийм л зохицуулалт орж ирж байгаа. Энэ нь юу бас нэг түгжрэлд нөлөөлөөд байгаа нэг зүйл энэ цагдаа хүлээж зогсдог, цагдаа ирэх хооронд түгжрэл үүсгэдэг ийм асуудлууд өнгөрсөн хугацаанд гараад байдаг. Энийг шийдэх зохицуулалтыг оруулж ирж байгаа л гээд ийм зохицуулалт байгаа.

О.Номинчимэг: Соронзонболд гишүүн тодруулъя.

Л.Соронзонболд: Гол нь орон нутгаас ирж байгаа иргэнийг нийслэлээс Улаанбаатарт зорчиж байгаа иргэнээ яаж бүртгэж, тоолох гэж байгаа юм бэ л гэж асуугаад байгаа юм. Тэрэн дээр ерөнхийдөө ярьж байгаа юм байгаа юм уу гээд

байхгүй юу. Жишээлбэл Дорнод аймгаас гэхэд төчнөөн хүн ирж байна гэдгийг яаж бүртгээд, дараа нь яаж төсвийн авлага үүсэх юм гээд байхгүй юу.

О.Номинчимэг: Ажлын хэсгийн 2 дугаар микрофон. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Хишгээгийн Нямбаатар дарга хариулъя.

Х.Нямбаатар: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Энэ UB смарт карт өөрөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн картыг уншаад тухайн аймаг тус бүрээр нь он, оноор нь хэчнээн хүн нийтийн тээврээр зорчсон тоонууд гарч байгаа юм. Тухайлах юм бол 2017 онд Дорнод аймгаас 169 мянган хүн зорчсон. 2024 онд 1 тэрбум 530 сая төгрөгийн ийм өр авлага үүсчхээд байгаа юм. Тэгэхээр өнгөрсөн жил бид нар ахмад настнуудын нийтийн тээврээр зорчилттой холбоотой ийм Үндэсний аудитын газраас гаргасан дүгнэлт өр авлагуудыг шийдэх зорилгоор хуульд нэмэлт өөрчлөлт оруулаад, Улаанбаатар хотод аймаг харгалзахгүй ахмад настнууд нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчих энэ хуулийг нээж өгсөн.

Мөн нөгөө талаасаа Улаанбаатар хотын харьяалалтай ахмадууд хөдөө орон нутагт зорчиход мөн ялгаагүй харилцан үнэ төлбөргүй зорчих ийм байдлыг нээж өгсөн. Тэгвэл энэ удаа Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай хуульд энэ өөрчлөлтийг оруулснаар цаашид нийслэлийн нийтийн тээврийн газар 21 аймагтай өр авлага үүсгэлгүйгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг орон нутгийн харьяалал харгалзалгүйгээр төлбөрийг нь Нийслэлийн нийтийн тээврээс даагаад хариуцаад явъя аа. Улаанбаатар хотын харьяалалтай хөгжлийн бэрхшээлтэй иргэд хөдөө орон нутагт мөн ялгалгүй нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчиж явъя гэдэг л ийм зарчмыг оруулж ирж байгаа юм. Ингэхгүй болохоор бид нарт хуримтлагдсан маш их хэмжээний өр авлагууд үүсээд үүнийгээ жил болгоны аудитын дүгнэлтээр өр авлагыг барагдуул гэдэг зүйл яригддаг. Аймгууд мэдээж хэрэг энийг төвлөрүүлж нийслэл рүү шилжүүлсэн ийм тохиолдол байхгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энийг нэг талдаа гаргаж шийдэж байгаа ийм зохицуулалт юмаа.

О.Номинчимэг: Болсон уу Соронзонболд гишүүн ээ. За төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух асууж дууслаа.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна. Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй гаргах гишүүд байна уу? Алга байна. Төслийн 5 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу? Алга байна. Төслийн 6 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан Төслийн 7 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Ингээд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Дараагийн 2 дугаар хууль буюу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье ээ.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Ажлын хэсгээс нэг тодруулга Байнгын хорооноос Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбоотойгоор нэг асуулт тодруулга байна. 2 дугаар зүйл буюу Зөрчлийн тухай хуулийн 3.4 дүгээр зүйл. Торгох шийтгэл гэдэг зүйл заалт байгаа. Энд эсвэл зам, авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх авах, сунгах, ангилал нэмэх гээд өөрчлөлт, нөхөн авах тээврийн хэрэгслийн эзэмшлийн шилжилт хөдөлгөөн хийх эрхийг нь хязгаарлана гэсэн өөрчлөлт орж ирж байгаа юм байна. Зам байгууламж ашигласны төлбөрийн хугацаанд. Энийг тайлбарлаж протоколд үлдээж өгнө үү. Хугацаанд нь төлөөгүй гэдэг нь яаж тооцогдох вэ гэдэг талаар.

2 дугаар зүйлийн буюу Зөрчлийн тухай хуулийн 3.4. Ажлын хэсгийн 3 дугаар микрофон Үнэнбат дарга.

М.Үнэнбат: Авто замын тухай хууль дээр замын байгууламж гэж юуг ойлгох талаар тодорхой зохицуулчихсан байгаа учраас тэрийг тэгээд 1 зүйл байгаа нь юу гэхээр одоо ингээд тухайн замын байгууламжаар зорчоод тухайлах юм бол нисэх ороод л буцахад замын байгууламжаар орж байгаа төлбөрийг автоматаар суутгадаг ийм цахимаар шууд автоматаар суутгадаг тийм зохицуулалтууд байгаа. Тэгээд энэ төлбөрөө төлөхгүй явж байгаад очоод үйлчилгээгээ авъя гэхэд нь энэ ямар нэгэн

торгуулийн асуудал биш та ингээд 5 мянган төгрөг юм уу, эсвэл 10 мянган төгрөгийн төлбөр төлөх ёстой юм байна. Энийгээ төлчхөөд тэр сунгалтаа хийлгэнэ үү л гэдэг. Энэ нөгөө талдаа иргэн хүний тэр зам замын байгууламж ашигласантай холбоотой үүргээ биелүүл биелүүлье гэдэг л зохицуулалт байгаа юм. Тэгэхээр энийг бол тэгж ойлгож хэрэглэж, хэрэглэж явна гэдгийг одоо хуулийн үзэл баримтлалын хүрээнд ингэж орж ирсэн талаар протоколд тэмдэглүүлэхийг хүсэж байна аа. Би Номинчимэг дарга нэмээд хариулчих уу?

О.Номинчимэг: Нямбаатар дарга 2 дугаар микрофон.

Х.Нямбаатар: Бид нар Замын хөдөлгөөний удирдлагын төв дээр камерын нэгдсэн систем ашиглалтад оруулаад хиймэл оюун ухаанаар тээврийн хэрэгслээ тоолдог, бусад бүх төрлийн зөрчлүүдээ тоолдог ийм механизмыг ашиглалтад оруулаад байгаа юм. 7 дугаар сарын 1-ний өдөр нийслэлийн замын хөдөлгөөнд нийтдээ 554043 тээврийн хэрэгсэл орсон байгаа. Энэ бол одоо урин дулаан болоод хүмүүс харьцангуй гадагшаа хөдөө гадаа явсантай холбоотойгоор аягүй сийрэг болж байгаа гэсэн үг. Хөдөлгөөнд оролцсон машинуудын 44490 нь хөдөө орон нутгийн машин. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татвараа төлөөгүй 22696 машин тухайн өдөрт хөдөлгөөнд оролцсон байгаа. Техникийн хяналтын үзлэгт ороогүй 10309 машин, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд ороогүй 22797, 100 мянган төгрөгөөс дээш хэмжээний торгуулиа төлөөгүй 5607, нийтдээ тухайн өдөрт 458 мянган зөрчил илэрсэн, зөрчлийг мессежээр 125 мянган хүнд илгээсэн байгаа.

Өөрөөр хэлбэл би яагаад энэ статистик тоог хэлж байна вэ гэхээр өнөөдөр бид нар замын хөдөлгөөний тэр нягтаршлыг бууруулахын тулд эдгээр төрлийн зөрчилтэй тээврийн хэрэгслүүдийн шилжилт хөдөлгөөнийг зогсоож байж энэ зөрчлийн хувь хэмжээ буурна л гэдэг юм ярья.

О.Номинчимэг: Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа. Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу? Алга байна. Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу? Алга байна. Төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Дагалдах хуулийн 3 буюу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье ээ.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Сайнзориг гишүүн 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргасан байна.

Сайнзориг гишүүний саналыг танилцуулъя. Төслийн 2 дугаар зүйлийн 7.5 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн албан тушаалтан гэсний дараа зөрчил үйлдсэн хүн хуулийн этгээдийн оршин суугаа буюу оршин байгаа газар эсвэл тухайн зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн нэгж гэж гэснийг 7.5 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн харьяалах шүүхэд хүсэлт гаргана гэснийг харьяаллын дагуу зөрчил үйлдсэн хүн хуулийн этгээдийн оршин суугаа оршин байгаа газар, эсвэл түүний зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн шүүхэд хүсэлт гаргана гэж өөрчилж, 4 дүгээр зүйлд шилжүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг.

Найруулгын илүү ойлгомжтой уншигдах байдлаар найруулсан ийм томьёолол байна. Зарчмын зөрүүтэй саналыг чинь шууд хураах уу?

За Сайнзориг гишүүний гаргасан төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан гарсан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураая. Санал хураалтад бэлдье. Гишүүд ээ санал хураалт.

78.6 хувиар санал дэмжигдлээ. Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан жоохон тодруулах найруулгын тодруулах ийм асуулт байна. Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан 4 буюу зөрчил үйлдэгдсэн газрын харьяалалтай холбоотой зүйл заалт байна. Энэ шинээр орж ирж байгаа дагнасан чиг үүрэгтэй алба, нэгжид зөрчлийн хэрэг бүртгэлийн харьяаллыг прокурор тогтооно гэдгийг протоколд утга агуулгыг нь илүү тайлбарлаж өгөөч ээ гэж ажлын хэсгээс хүсэж байна. Субъектийн хувьд уу, энэ өмнөх зүйл заалт нь болохоор газар нутгийн дэвсгэрийн хувьд зөрчил илрүүлсэн тохиолдолд харьяаллыг прокурор тогтоодог байсан. Шинээр орж байгаа энэ зүйл маань субъектийн хувьд нь хэн зөрчлийг илрүүлснээс хамаараад прокурор харьяаллыг нь тогтоох заалт уу, эсвэл өөр утгатай юу гэдгийг ажлын хэсгийн 6 дугаар микрофон нээе. Хариулж, тодруулж өгнө үү?

Ц.Батболд: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. УЕПГ-ын туслах прокурор Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Батболд хариулъя. Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа бол Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу нутаг дэвсгэрийн харьяаллаар шалган шийдвэрлэж байгаа. Зөвхөн хуульд заасан тохиолдолд прокурор харьяаллыг нутаг дэвсгэрийн зарчмаас гадуур тогтоож өгөх ийм зохицуулалт байгаа. Энэ зохицуулалтууд дотор бүтцийн хувьд яг эрх бүхий зөрчил шалгах эрх бүхий байгууллагын дагнасан газар нэгжид харьяалал тогтоох ийм зохицуулалт байхгүйгээс болоод зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой бас зарим хүндрэлүүд үүсэж байгаа. Тухайлах юм бол одоо Тээврийн цагдаагийн албан дээр тээврийн цагдаагийн зөрчлийн шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа хэргүүд дээр бас нутаг дэвсгэрийн асуудал дээр хүндрэл бэрхшээл гардаг. Энэ нь тээврийн ЦЕГ-аас ирүүлсэн удаа дараагийн судалгаа түүний дүн манай прокурорын байгууллагаас бас хийсэн судалгааны дүнгээр ингээд тогтоогдож байгаа.

Тийм учраас энэ харьяалал тогтоох энэ үндэслэл дээр зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллагын дагнасан газар нэгжид харьяалал тогтоож өгөх ийм боломж энэ хуулиараа бий болгох нь энэ боломжтой ийм зохицуулалт аа гэж бодож байна.

О.Номинчимэг: Баярлалаа. Тэгэхээр энэ нөгөө жоохон найруулгын хувьд л хэрэгжүүлэх явцад өмнөх өгүүлбэр маань тиймээ явцад зөрчил илрүүлсэн бол гээд нэмж орж байгаа маань эсгүй бол дагнасан чиг үүрэгтэй алба нэгжид зөрчлийн бүртгэлийн харьяаллын прокурор тогтоно оо гээд тэгж байгаа. Тэгэхээр дагнасан чиг үүрэгтэй алба нэгж маань өөрөө зөрчил илрүүлсэн бол биш нэгж өөрөө зөрчил хянан шийдвэрлэгдэж байгаа ийм бүтцэд бол зөрчлийн хэрэг бүртгэлийн харьяаллыг нь прокурор тогтоно оо гэсэн агуулгаар гэж ойлгож байгаа нь зөв үү? Найруулга дээр энэ нөгөө жоохон ойлгомжгүй байгаа учраас л асуугаад байгаа юм.

Ц.Батболд: Энэ юун дээр эрх бүхий зөрчил шалгах эрх бүхий байгууллагын дагнасан чиг үүрэгтэй алба нэгж бол зөрчлийг өөрсдөө илрүүлнэ, шийдвэрлэнэ. Ийм байдлаар энэ төсөл дээр бичигдсэн байгаа. Эсвэл дагнасан чиг үүрэгтэй алба нэгжид зөрчлийн хэрэг бүртгэлтийн харьяаллыг прокурор тогтоно гээд бичсэн байгаа учраас боломжтой л гэж үзэж байгаа.

О.Номинчимэг: Найруулга дээр энэ дээр бас Байнгын хороо анхааръя. Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Пүрэвдорж гишүүнээр тасалъя. Уянгахишиг гишүүн ирцээрээ уучлаарай Пүрэвдорж гишүүн юм уу?

Б.Пүрэвдорж: Энэ прокуророос нэг юм асуугаадахъя л даа. Энэ гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль дээр юу яачихсан байгаа юм. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийг зөрчих юм бол Зөрчлийн хуулийг нь тэдээр торгоно гээд яг зүйл ангийг нь би бас санахгүй байна. Тэгвэл би энэ асуултаа орхиё.

О.Номинчимэг: Уянгахишиг гишүүн асуулт асууя.

Г.Уянгахишиг: Энэ дээр 6.6 дээр хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх гэдэг заалтыг өөрчлөн найруулж байгаа юм байна. Тэгээд энэ дээр яг найруулгын хувьд гэдэг юм уу, яг ойлгож авч чадахгүй байгаа зүйл нь юу вэ гэхээр өмнө нь ер нь бол хялбаршуулсан газар дээр нь эсвэл хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэнэ гэдэг байсныг 2 тусад нь бүүр ялгаж байгаа гэж ойлгож болох уу? Өөрөөр хэлэх юм 1 дүгээр зүйл дээр нь болохоор зөрчлийг газар дээр нь шийдвэрлэх нөхцөлүүдээ ялгаж тусгаад, дараагийнх нь болохоороо хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэнэ гэж байгаа юм байна гэж ойлгож байна. Энэчээнээс нэг асуух гээд байгаа юм болохоор бас 2 дугаар зүйл дээр нь зөрчил үйлдэгдсэн нь тодорхой, холбогдогч зөрчил үйлдсэнээ сайн дураараа хүлээн зөвшөөрсөн боловч учруулсан хохирлыг нотлох баримтаар тогтоох шаардлагатай бол эрх бүхий албан тушаалтан зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэнэ гэхийсэн байна. Тэгэхээр энэ нь нөгөө яг энэ 2 заалтын ялгааг буюу газар дээр нь гэдэг нь юу гэсэн утгатай орж ирж байгаа юм? Хялбаршуулсан журмаар гэдэг нь ямар утгатай орж ирж байгаа юм. Өмнөх зохицуулалтаасаа гол ялгаа үүсгэж байгаа зүйл нь юу юм гэдгийг процессын хувьд тиймээ.

О.Номинчимэг: Ажлын хэсэг 6 дугаар микрофон.

Ц.Батболд: Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. 6 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт орж байгаа өөрчлөлт яг саяын таны хэлсэн газар дээр нь болон хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэх ажиллагааны процессыг ялгаж өгч байгаа. Хуучин хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд энэ маань бас сайн ялгагдахгүй байгаагаас бас хүний эрх зөрчигдөх, процессын хуульд заасан бас журам алдаа гарах иймэрхүү нөхцөл байдал ажиглагдаж байсан. Төслийн энэ 1 дүгээр зүйлд зөрчил үйлдэгдсэн нь ил тодорхой гэдэг бол зөрчлийн хэрэг бүртгэлд явуулах шаардлагагүй. Өөрөөр хэлбэл материалжуулан шалгах шаардлагагүй ийм зөрчлийг газар дээр нь шийдвэрлэж байгаа энэ тохиолдлыг хэлж байгаа юм. 2 дугаар зүйлд заасан зохицуулалт нь бол материалжуулж шалгах шаардлагатай буюу нотлох баримт цуглуулах ийм шаардлагатай тохиолдолд нотлох баримтаа материалжуулж шалгаад тэгээд хялбаршуулж шийдвэрлэж байгаа энэ зохицуулалтыг ялгаж ингэж 2 тусад нь ингэж тодруулж найруулж ингэж төсөлд тусгасан байгаа.

О.Номинчимэг: Уянгахишиг гишүүн тодруулъя.

Г.Уянгахишиг: Энэ нөгөө эхний хэсэг дээр шийдвэрлэх ажиллагааг автоматжуулсан системээр гүйцэтгэсэн бол шийтгэлийн хуудсыг эрх бүхий албан тушаалтны тоон гарын үсгээр баталгаажуулж болно гэчихсэн байна тиймээ. Тэгэхээр энэ нь яг ямар процесс явна гэсэн үг вэ? Энэ бол нөгөө яг газар дээр нь шийдэх тухайд л яваад байгаа юм байна гэж ойлгож байна. Зөв үү?

О.Номинчимэг: Ажлын хэсэг 6 дугаар микрофон. Ажлын хэсэг 2 дугаар микрофон Нямбаатар дарга.

Х.Нямбаатар: 7 хоногт дунджаар нэг 5 сая зөрчил үйлдэгдэж байгаа юм. Тэгээд өдөрт жишээлбэл ЭБАТ буюу эрх бүхий албан тушаалтан одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх хуулиар нэг 17 мянга орчим зөрчлийн хэрэг дээр эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж амжиж байгаа юм. Өөрөөр хэлбэл үлдсэн тэр хэдэн сая зөрчлийг бүгдийг нь нэг бүрчилж ЭБАТ баталгаажуулж чадахгүй байгаа юм. Тийм учраас одоогийн оруулж ирж байгаа нэмэлт, өөрчлөлтийн гол үндсэн агуулга нь хиймэл оюун ухаан бүхий камераар тухайн өдөрт нь гарсан зөрчлийг тухайн камерын хяналтын систем дээр суусан тэр өдрийн жижүүрийн албаны эрх бүхий албан тушаалтан бүхэлд нь нэг дор баталгаажуулж гарын үсэг зурахыг л ярьж байгаа.

Өөрөөр хэлбэл бид нар хэрвээ одоо яг энэ өдөрт ингээд үйлдэгдэж байгаа өдөрт сая гаран зөрчил үйлдэгдэж байгаа гэж үзэх юм бол яг хүн биеэрээ бүх зөрчлийг шалган шийдвэрлэж бүгдэд нь гарын үсэг зурж, хяналт тавьж ажиллах юм бол манайд хэдэн сая ЭБАТ буюу эрх бүхий албан тушаалтан томилж ажиллуулах шаардлагатай болчихоод байгаа юм. Тийм учраас камерын нэгдсэн системээрээ бид нар хиймэл оюун ухаанаар зөрчлийн бүх өгөгдлийг кодыг нь бичиж оруулаад тухайн гаргасан зөрчил гаргагчийн зөрчлийг тухайн өдрөөр нь тэр өдрийн ЭБАТ бүхэлд нь баталгаажуулж нэг дор гарын үсэг зурах ийм зохицуулалтыг л оруулж ирж байгаа гэж товчхондоо ойлгож болно.

О.Номинчимэг: Уянгахишиг гишүүн тодруулъя.

Г.Уянгахишиг: Энэ дээр тэгэхээр нөгөө яг 1 дүгээр өгүүлбэр нь болохоор эрх бүхий албан тушаалтан зөрчлийг газар дээр нь шийдвэрлэнэ гэж байгаа шүү дээ тиймээ. Тэгэхээр саяынх чинь газар дээр нь гэхээр яагаад ч юм яг ингээд нөгөө үйл явдал болж байгаа газар дээр гэдэг шиг ойлгогдоод байна л даа. Өөрөөр хэлбэл тухайн зөрчил яг болчихсон тэрэн дээр жишээлбэл цагдаа байж байгаа юм шиг. Тэгэхээр саяынхаар бол нөгөө бид нарын яриад байгаа хэмжилт хяналтын төхөөрөмжөөр зөрчил тогтоогдчих гээд байна шүү. Тэгэнгүүт тэр зөрчил тогтоогдчихонгуут тэрийг газар дээр нь шийдвэрлэнэ гэдэг нь шууд тэр төхөөрөмжөөрөө буюу цахимаараа шийдвэрлэх тухай асуудал яригдаад байна гэж ойлголоо. Тэгэхээр энэ газар дээр нь гэдэг үгийгээ газар дээр нь шийдвэрлэх гэдэг үгээ нэг өөрчлөх ёстой юу, үгүй юу. Одоо газар дээр гэдэг маань яг нэг ийм локэйшн бэйсед буюу яг нэг тухайн цэг дээр гэдэг шиг ойлгогдоод байна л даа. Тэгэхээр энийг бас нэг та хэд маань бодолцож үзвэл яадаг юм бол? Энэ үгээрээ байхад ойлгомжтой юу?

О.Номинчимэг: 2 дугаар микрофон Нямбаатар дарга.

Х.Нямбаатар: Зөрчлийн тухай хууль 2017 оноос хүчин төгөлдөр үйлчилсэн. Зөрчил шалган шийдвэрлэх хуулийг тухайн үед бид бүхэн шинээр боловсруулж, материаллаг хуулиа дагуулж процессын хуулийг боловсруулсан юм. Тэгээд энэ зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа 3 үндсэн төрлийн 3 үндсэн төрөл хэсгээс бүрдэж байгаа юм. Нэг хэсэг нь яг газар дээр нь үйлдэгдэж байгаа зөрчлийг газар дээр нь шийдвэрлэх буюу замын голд зогсож байгаа цагдаагийн зохицуулагч улаан гэрлээр орсон тээврийн хэрэгслийг зогсоогоод, тухай бүрд нь торгууль шийтгэлээ ноогдуулаад явахыг газар дээр нь шийдвэрлэх ажиллагаа гэж үзэж байгаа.

2 дахь төрлийн зөрчил нь тодорхой төрлийн зөрчлийг материалжуулан шалгаад эцэст нь зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээд захиргааны шийтгэл ноогдуулах процессын ажиллагааг хэлж байгаа юм. 3 дахь төрлийн бүлэг зөрчлийг бид нар бүүр тусад нь нэг бүлэг болгож оруулж ирсэн нь жижиг гэмт хэргийн шинжтэй тодорхой төрлийн зөрчлийг тодорхой төрлийн процессын ажиллагаа явуулаад шүүхээр оруулж шийдвэрлүүлдэг ийм процесс. Ийм 3 төрлийн зөрчил хэсгийг зөрчлийн ажиллагаа одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Зөрчил шалган шийдвэрлэх хуулинд байгаа. Тэгэхээр газар дээр нь шууд тэр зөрчлийг шийдвэрлэх боломжтой ажиллагаа бол жишээлэхэд саяын хэлдэг замын голд зогсож байгаа цагдаагийн зохицуулагч тухайн зөрчлийг газар дээр нь шийдвэрлэж болно. Нөгөө талдаа яг тухайн рийл таймаар нөгөө камерын хяналтын нэгдсэн төвийн камерын системд зөрчил нь үйлдэгдсэн тохиолдолд тухай бүрд нь зөрчлийг нь тухайн зөрчил гаргагчид мессежээр болон бусад хэлбэрээр хүргүүлж байгаа процесс 2 яг адил төрөл. Одоо газар дээр нь тухайн асуудлыг зөрчлийг шалган шийдвэрлэж байгаа процессын нэг төрөл хэлбэр болж байгаа. Тухайн зөрчлийг ЭБАТ яаж баталгаажуулах вэ гэхээр бөөнд нь тэр өдрийн гарсан...

О.Номинчимэг: Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж дууслаа. Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Дашдондогийн Ганбат гишүүнээр тасалъя. Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууя.

Да.Цогтбаатар: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Энэ өмнө болохоор энэ нөгөө замын хөдөлгөөний камерын системтэй холбоотойгоор торгуулж байгаа нөгөө хариуцлага хүлээх хугацаа гэж нэг хугацаа байх шиг байсан 14 хоног ч билүү. Тэгээд тэр нь дуусаад төлөх үүрэг нь нөгөө хөөн хэлэлцэх хугацаа гэдэг шиг төлөх хугацаа нь дууссаны дараа энэ нөгөө торгочихсон шийтгэл шийтгэврийг шүүх хүчингүй болгож чадахгүй, прокурор хүчингүй болгож чадахгүй байгаад байсан тэрийг шийдэж орж ирж чадсан болов уу гэж тодруулах гэсэн юм.

О.Номинчимэг: Ажлын хэсэг 6 дугаар микрофон прокуророос хариулах уу?

Ц.Батболд: Зөрчлийн хуульд заасны дагуу торгууль шийтгэл оногдуулсан тохиолдолд тухайн хүн хуулийн этгээд тэр торгууль шийтгэлийг заавал биелүүлэх үүрэгтэй. Үүнд ямар нэгэн хугацаа үйлчлэхгүй. Тийм одоо хүчингүй болох ийм зохицуулалт хуульд байхгүй. Сайн дураар биелүүлэх хугацаа 14 хоног байгаа. Энэ хугацаандаа төлөхгүй торгуулийн хэмжээг нэмэгдүүлнэ. 5 сар хүртэл хугацаагаар торгуулийн хэмжээг нэмэгдүүлээд тухайн хугацаанд торгуулиа биелүүлээгүй тохиолдолд шүүхэд хүсэлт гаргаж албадан гүйцэтгүүлэх, эсвэл нийт тустай ажил хийлгэх ийм шийтгэл оногдуулах хүсэлтийг гаргаж шийдвэрлүүлэх ийм зохицуулалттай байгаа.

О.Номинчимэг: Цогтбаатар гишүүн тодруулъя.

Да.Цогтбаатар: Энэ эрүүгийн хэрэг дээр чинь хөөн хэлэлцэх хугацаа гээд байдаг. Зөрчлийн хэрэг чинь нэг 6 сар ч билүү байсан юм. Тэгээд тэрэн дээрээ 6 сарынхаа дотор төлүүлэх арга хэмжээ авч чадаагүй бол хүчингүй болгох заалттай. Тэгээд тэр заалтыг нь хэрэгжүүлэх гэхээр захиргааных нь шүүх хэрэгжүүлэхгүй манайх биш гэдэг бүүр бичиг нь байгаа. Тэгээд прокурорт нь хандахаар прокурор нь бас шүүх рүү яв ч билүү ингээд нэг ийм хийдэл бол байсан юм. Тэрийг л тодруулаад байгаа юм. Одоо энэ хууль дээрээ ямар нэгэн аргаар заавал төлүүлнэ, болохгүй бол шүүхэд хандаад заавал төлүүлэх байдлаар хийчхэж. Зөв үү мөн мөн.

О.Номинчимэг: Энэ жоохон тийм ойлголтын нөгөө тайлбарлаж өгснөөс ажлын хэсгийн 2 дугаар микрофон Нямбаатар дарга.

Х.Нямбаатар: Цогтбаатар гишүүн таны энэ ярьж байгаа зүйл энэ хөөн хэлэлцэх хугацаа гэдэг 2 өөр 2 тусдаа ойлголт. Өөрөөр хэлбэл хууль зүйн шинжлэх ухаанд эрүүгийн болон захиргааны болон иргэний хариуцлагад татаж болох хугацааг хөөн хэлэлцэх хугацаа гэж үзэж байгаа. Өөрөөр хэлбэл тэр зөрчил үйлдсэнээс хойш, гэмт хэрэг үйлдсэнээс хойш, иргэний эрх зүйн зөрчил үйлдсэнээс хойш тухайн зөрчил гаргагчийг зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий субъект дуудаж ирүүлээд, зөрчлийн процессыг эхлүүлээд, зөрчлийн процессыг дуусгавар болгоод, зөрчлийн шийтгэл ноогдуулж болох тэр боломжит хугацааг хөөн хэлэлцэх хугацаа гэж байгаа юм. Зөрчил үйлдсэнээс хойш 6 сарын дараа зөрчлийг дахин шалгах, нөхөж шалгах тухай ойлголт байхгүй. Өөрөөр хэлбэл хөөн хэлэлцэх хугацаа дуусчхаж байгаа юм. Таны саяын ярьж байгаа зүйл нь юу вэ гэвэл нэгэнт шийтгэл ноогдуулсны дараа 6 сар өнгөрчихсөн бол торгуулиа төлөхгүй байж болох уу гэвэл энэ болохгүй. Өөрөөр хэлбэл ял шийтгэл гарцаагүй байдаг зарчимтай яг адилхан шийтгэл ноогдуулсан л бол тэр шийтгэлийг тэр зөрчил гаргагч нь зайлшгүй биелүүлэх үүрэгтэй. Тэгэхээр энэ 2 өөр тусдаа ойлголт оо гэдгийг л хэлэх гэсэн юм.

О.Номинчимэг: Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууя.

Д.Ганбат: Ингээд хотоос асуудлаа оруулаад, энэ хуулийнхаа араас яваад байгаа нь их сайн байна аа. Манай Нямбаатар дарга чинь яасан нүднээс гарчхаа вэ дээ. Хотод 2 жил яваад бас үзээд л байдаг тиймээ. Үр дүн ер нь ямар байна вэ? Гайгүй болчих гээд ч байгаа юм шиг хэрүүл их хийгээд байх шиг байна. Мэдээж хэрэг хэрүүлгүй уруулгүй, хэл амгүй юм гэж байхгүй байх аа. Энэ иргэд ядуу байна аа, ард түмэн хүнд байна аа. Ингээд торгууль шийтгэл хиймэл оюун ухаан оруулж ирээд ажиллаад байдаг. Энийг чинь тэгээд яг тэр торгууль шийтгэлийг чинь төлж барахаар байна уу? Ямар байна вэ? Хэрэв одоо барж чадахгүй боломжгүй бол яах юм? Тэгвэл энэ гацаад байгаа, түгжрээд байгаа энэ хөдөлгөөнд ордог машин тэрэгнийхээ асуудлыг янзлах уу? Тийм торгууль шийтгэлээ төлдөггүй хүмүүс нь унаа малгүй л явж байг л дээ. Ийм юм байж болох уу, болохгүй юу? жоохон бас амьдралтай хууль бид нар яримаар байна л даа тийм. Энийг нэг тодруулчихъя.

О.Номинчимэг: Ажлын хэсэг 2 дугаар микрофон Нямбаатар дарга.

Х.Нямбаатар: Ганбат гишүүний асуултад хариулъя аа. Би сая та хэдийг нөгөө юм ярьж байхад би уг нь статистик танилцуулсан юмаа. 7 сарын 1-ний өдөр Улаанбаатар хотын замын хөдөлгөөнд 554043 машин оролцсон байна аа. Эдгээрээс татвараа төлөөгүй 22696, техник хяналтын үзлэгт ороогүй 10309, жолоочийн албан журмын хариуцлагын даатгал төлөөгүй 22797, 100 мянган төгрөгөөс дээш торгуулиа төлөөгүй 5607 машин хөдөлгөөнд оролцож байна нэг өдрийн байдлаар.

Тэгэхээр Ганбат гишүүний би саяын асууж байгаа асуултыг ер ойлгосонгүй. Торгууль төлөхгүй байгаа машиныг нэг бол хөдөлгөөнд бүр оролцуулахаа боль. Нөгөө талдаа ард түмэн ядуу байна гэдэг энэ 2 ийм эсрэг тэсрэг зүйл ярих шиг боллоо. Тэгэхээр торгууль шийтгэлээ торгууль шийтгэл гаргахгүй, зөрчил гаргахгүй явах нь өнөөдрийн бид нарын л Үндсэн хуулийн Үндсэн хуульт байгууллын л үндсэн зарчим. Тийм учраас эрх зүйн соёлыг л бий болгох үүднээс энэ асуудлыг оруулж ирж байгаа. 2 гэвэл та бид 2 Хууль зүйн байнгын хороонд 2021 онд харьяалагдан ажиллаж байхад Ардын хувьсгалын 100 жилийн ойгоор бүх шийтгэл торгууль шийтгэлийг өршөөж уучлах хууль батлуулсан. Энэний үр дүнд торгууль шийтгэлийн хувь хэмжээ нэмэгдэх болов уу гэдэг ийм хүлээлттэйгээр бүх өршөөл уучлал үзүүлсэн. Харамсалтай нь торгууль шийтгэлийн хувь хэмжээ төдийлөн нэмэгдэж төлөгдөөгүй. Тэгэхээр торгууль төлөхгүй байхыг ялангуяа Их Хурлын индрээс уриалбал энэ өөрөө нэг лизм буюу эрх зүйг үгүйсгэх үзлийн хамгийн том тод илрэл болно. Тийм учраас энэ өөрөө хууль дээдлэх зарчмын үүднээс би бас ийм зүйлийг бид аль болох ярихгүй байвал зөв байх болов уу. Цаашид эрх зүйн соёлыг яаж бий болгох вэ гэдэг талаасаа хэдүүлээ ярих нь зөв байх аа гэж бодож байна. Би сая танд нийт торгууль шийтгэлтэй машины хөдөлгөөнд оролцож байгаа тоог хэллээ.

О.Номинчимэг: Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Нямбаатар дарга юу гээд улс төржөөд явчхав аа? Та аж ахуйн ажил хийж байгаа хүн шүү тэнд. Та бүүр чуулганы юун дээр байдаг шиг юм шиг л юм яриад уналаа тэгж таарахгүй байх аа. Ер нь ингэж болохгүй. Бид бүхэн сонгууль дөхүүлээд санал авах гэж байгаа юм шиг нөгөө торгуулийг нь хөнгөлдөг, ер нь байхгүй болгодог тийм хууль дахиж гаргаж болохгүй байх гэж бодож байна. Таны ярьж байгаа зарим зүйлтэй санал нэг байна, заримтай нь биш байна. Одоо наад татвар түрээсээ болиорой. Улаанбаатар хот гэдэг чинь бөөн л татвар авдаг тийм

газар болчихсон юм уу, хаашаа юм тиймээ. Тэгэхээр нэг хувийнхаа татварыг хаана юунд зарцуулаад байна вэ? Бид нар чинь ямар орчинд амьдраад байгаа юм. Энэ Улаанбаатар хот. Энэ чинь хот юм уу, юу юм. Юу болчихоод байгаа юм ойлгохгүй байгаа шүү заримыг нь. Энэ дээр анхаарч ажиллана шүү хотын нөхдүүд.

О.Номинчимэг: Ганбат гишүүн яг нөгөө зүйл заалттай холбоотой бас асуулт асууж, санал хэлж байвал их сайн байна. Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? 4 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал Пүрэвжавын Сайнзориг гишүүнээс гарсан байна.

Төслийн 4 дүгээр зүйлийн мөн зүйлийн 6.8 дахь заалтын 7.6 дугаар зүйлийн 9 дэх хэсэг 7.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэг гэснийг 7.1 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 7.6 дугаар зүйл, 7.7 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 7.9 дүгээр зүйл, 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7 дахь хэсгийг хэсэг, 7.11, 7.12, 7.15, 7.17 дугаар зүйл гэж гэснийг хасах санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг. Сайнзориг гишүүн тайлбарлая.

П.Сайнзориг: Гишүүдийн бас энэ Зөрчлийн хууль, Зөрчил шалган шийдвэрлэх хууль дээр хэлж байгаа саналууд зөв байх аа. Ер нь зүгээр Зөрчлийн хуулийг батлаад бас тодорхой цаг хугацаа өнгөрч байгаа. За нэг 2500 үйлдлийг зөрчилд тооцож одоогоор торгууль ноогдуулж байгаа. Энийг 1500 руу бууруулаад тэр хасагдаж байгаа мянга орчим зөрчлийг захиргааны эрх зүйгээр албадлага буюу сануулах байдаг юм уу, бусад байдлаар шийдвэрлэдэг хууль эрх зүйн орчныг бас намар би бас өргөн барина аа. Тэгээд энэ бас ард иргэдэд бас зарим ер нь зүгээр яах вэ манай төрийн байгууллагууд байгаа юм. Аль болохоор л бүх үйлдлүүдийг нөгөө торгууль тавиад авчихъя гэдэг бас энэ яам агентлагуудын хандлага байдаг. Энийг бас өөрчилж ялангуяа зүгээр хүний амь нас эрсдэж байгаа энэ замын хөдөлгөөний аюулгүй байдал дээр ч гэдэг юм уу, энийг нь нэлээн олон онцгой анхаарч шийднэ гэдэг зүйлийг 1 дүгээрт хэлмээр байгаа юм.

2 дугаарт яах вэ. Энэ санал юу ямар учиртай вэ гэхээр Баасанжаргал гишүүнээр ахалж байгаа Хүний эрхийн багц хуулийн ажлын хэсэг дээр уг асуудал нь давхцаад тэгээд энийг бас нэг шийдэх хувилбар нь тэндээ яригдаж байгаа учраас хасъя гэж байгаа юм энэ удаад. Өөрөөр хэлэх юм экологийн цагдаагийн албыг бас Монгол Улсын Засгийн газраас бас Цагдаагийн ерөнхий газар дээр тухайлан байгуулчихаад байгаа боловч гэмт хэргээ бол харьяалан шийдэж байгаа. Гэтэл зөрчлүүдээ шийдэж чадахгүй зарим орон нутагт уг нь байгаль орчны байцаагч байхгүй, байгаль орчны байцаагчийн эрхтэй этгээдүүд тусгай хамгаалалтай газар нутаг дээр ажилладаггүй ч гэдэг юм уу эргээд экологийн зөрчлүүд бас шийдэгдэхгүй бас хийдэх тохиолдлууд ер нь гараад байгаа. Тэгэхдээ энийг бас Баасанжаргал гишүүний ажлын хэсэг нухацтай ярьчихъя гэж байгаа учраас энэ удаад нь бас эндээс хасчихъя гэдэг байдлаар бас орж байгаа шүү гэдэг зүйлийг би бас тайлбарлаад хасаж байгаа саналаа бас хэлж байгаа юм. Энийг тэгээд Баасанжаргал гишүүний ажлын хэсэг нэг мөр шийдээд явах юм байна гэж Хууль зүйн байнгын хороо бас ярьж байгаа учраас хасаж байгаа гэдэг зүйлийг хэлье. Тэгээд гишүүд дэмжээд өгөхийг хүсье ээ.

О.Номинчимэг: Сайнзориг гишүүний гаргасан саналтай холбогдуулан санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлдье. Сайнзориг гишүүний гаргасан саналтай холбогдуулан санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлдье.

Сайнзориг гишүүний төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан гаргасан Зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

86.7 хувиар дэмжигдлээ. Төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Төслийн 5 дугаар зүйлийг хэлэлцэж хэлэлцэж дууслаа.

Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Төслийн 6 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчилд шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг би танилцуулъя.

О.Номинчимэг: Дараагийн асуудалдаа оръё. Ажлын хэсэгт баярлалаа.

Хоёрдугаар асуудал. Улсын Дээд шүүх Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо болон ХЭҮК-ын 2026 оны төсвийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцье ээ.

Ажлын хэсгийг танхимд оруулъя.

Улсын Дээд шүүхийн 2026 оны төсвийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцье. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга Заяадэлгэр, Шүүхийн сургалт мэдээллийн хүрээлэнгийн захирал Эрдэнэчимэг арай ирээгүй байна уу? Улсын дээд шүүхийн ерөнхий нягтлан бодогч Эрдэнэцэцэг ирсэн байна аа.

2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар Улсын дээд шүүхийн 2026 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга Заяадэлгэр танилцуулсан бөгөөд гишүүд асуулт асууж хариулт авч дууссан.

Одоо Улсын дээд шүүхийн 2026 оны төсвийн төслийн урсгал зардал болон хөрөнгө оруулалтын зардалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Баасанжаргал гишүүнээр тасалъя. Баасанжаргал гишүүн, Энхбаяр гишүүнээр тасалъя.

Х.Баасанжаргал: Улсын дээд шүүхийн төсвийн төсөөлөлтэй танилцлаа.

Тэгэхдээ энэ дээр би сая ойлгохдоо энэ нөгөө тодотголтой холбоотой бас асуудлууд хараахан тусаагүй гэж ойлгож байна. Ялангуяа энэ шүүхийн сургалт судалгааны зардлын асуудал бол нэлээн анхаарал татаж байна.

Цаашид ер нь энэ асуудлуудыг нэлээн ийм 4, 5 жилээр төлөвлөсөн байдлаар тэгээд бид нар чинь нэг ийм жилийн жилд л нэг ийм шүүхийн төсөв яриад л шүүхийн төсвийг нэмэх ёстой, анх баталснаас нь бага орж ирлээ. Байнгын хороо ингээд баталсны хэрэг гарахгүй байна гээд л яг дахиад л намар яг энэ ирвэл дахиад л яв болно. Тэгэхээр энэ бүхэн дээр ер нь нэг манай парламентын зүгээс ч тэр Улсын Дээд шүүхийн зүгээс ч тэр, ШЕЗ-ийн зүгээс ч тэр аль аль нь анхаараад ер нь энэ бүх тавиад байгаа энэ зардал чинь юунд чиглэж, ямар зорилготой, ямар үр дүнд хүрээд хэнд ямар үйлчилгээ үзүүлэх зорилготой гээд ингээд нэг ийм том дүр зургаар нь харсан танилцуулга мэдээллүүдийг ер нь энэ мэдээлэл шинжилгээтэйгээ хамт давхар бас гишүүдэд өгч байвал их хэрэгтэй байна. Тэгээд энэ нь өөрөө бас их ач холбогдолтой. Шүүхийн байгууллагыг яг л нэг гүйцэтгэх эрх мэдлийн бас нэг байгууллагатай адилхан. Аль нэг яамтай адилхан үзэж хардаг ханддаг хандлага маш түгээмэл байдаг юм байна. Одоо энэ төсвийн тодотголтой холбоотой 9 хувийг нийт ажилтнуудын 9 хувийг бууруулна гээд байгаа.

Тэгэхээр одоо миний тооцоолж байгаагаар энэ шүүхийн гүйцэтгэх үйлчилгээний ажилтан гүйцэтгэх ажил гээд ингээд эдгээр албан тушаалтнууд гээд бодохоор нийтдээ 160, 170 хүний ыг ажлаас нь чөлөөлөх шаардлага үүсэх ийм шинжтэй байгаа. Арай ч тэр 9 хувьд нь шүүгчдийг бас оруулахгүй байлгүй дээ тэ. Тэгэхдээ би энийг судлаад үзэхээр өмнө нь 2003 онд эдийн засаг хүндэрсэн гэдэг үндэслэлээр бүх төрийн албан хаагчдыг чөлөөлөөд тэгж байхад нэг л удаа шүүхээс дал гаруй албан тушаалтныг чөлөөлж байсан юм байна лээ 2003 онд. Түүнээс хойш хэдийгээр эдийн засаг хүндэрсэн ч гэсэн хэзээ ч ингэж шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтнуудын тоог цөөлөх гэдэг энэ процесс огт явагдаж байгаагүй. Ядаж нэмэгдүүлэх, нэмэгдүүлдэггүй юм гэхэд дордуулахгүй байх л гэдэг ийм бодлого явж ирсэн.

Тэгэхдээ харамсалтай нь бид нар эдийн засаг хүндрэлтэй байгаатай холбоотой яг энэ шүүхийн байгууллагын үйл ажиллагааг яг бусад төрийн байгууллагатайгаа Ижилтгэж, адилтгаж үзээд байгаа дээр ер нь нэг хаа хаанаа ер нь анхаарах ёстой байх. Тэгээд бодлогын хувьд ч гэсэндээ Улсын Дээд шүүхийн зүгээс тэр Улсын Дээд шүүхийн сургалтын судалгааны байгууллагын хувьд бас тэр зардал төсвийнх нь байж байгаа байдал гээд л ингээд л бусад гүйцэтгэх эрх мэдэл Ерөнхийлөгч гээд ингээд бусад эрх мэдлийн байгууллагуудтай харьцуулахад бас л маш бага л байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ зүйлүүд дээрээ ч гэсэн хаа хаанаа анхаараад бид нар гишүүдэд өгч байгаа мэдээллийг нэлээн ийм том дүр зургаар нь далайцтайхан шиг ийм мэдээллүүдээр маш сайн хангах ёстой байх. Манай ХЗБХ ч гэсэндээ цаашид энэ дээр бас бодлоготой байх ёстой байх гэж бодож байна. Баярлалаа.

О.Номинчимэг: Үг хэллээ.

Баасанжаргал гишүүний бас саналтай нэг байна. Бид 3 нөгөө эрх мэдлийн салаа мөчийнхөө нэгийг ер нь төрийн 3 өндөрлөг гэж хэлэхдээ ч хүртэл орхичихдог. Тэгээд шүүхийн төсвийг ер нь Сангийн яамны мэргэжилтний хэмжээнд л шийдээд л явдаг практик байсан уг нь энийг өөрчлөх гэж энэ дараа жилийн төсвийг нь бас ХЗБХ авч хэлэлцдэг энэ дэгийг оруулж ирсэн. Гэхдээ бас нягт нямбай энэ дээр ажиллах цаг хугацааны болон тэ мэдээллийн энэ урсгалыг сайжруулах тал дээр бас хаа хаанаа анхаарах ёстой гэж бодож байна.

Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлье.

Б.Энхбаяр: Зарчмын хувьд Баасанжаргал гишүүнтэй санал нэг байна.

Өөрөөр хэлбэл миний хувьд бол 2021 онд энэ шүүхийн хуулийн ажлын хэсгийг Улсын Их Хурал дээр манлайлж ахалж батлуулж байсан. Ингэхдээ шүүхийн эдийн засгийн бие даасан байдлыг хангахын тулд ХЗБХ хаврын чуулганаар төсвийг урьдчилан хянаж улмаар Сангийн яаманд хүргүүлж байх энэ зохицуулалтыг оруулж байсан юм. Улмаар тэр үеэс хойш шүүгчийн туслахуудын цалин нарийн бичгийн даргын туслахуудын цалин, хөрөнгө оруулалт гэж ярих юм бол жил тутам, 2 жилийн өмнөхөөс шүүхийн төсөв 2, 3 дахин нэмэгдчихсэн юм. Бид нар Улсын Их Хурал бол шүүхэд маш их хайр халамжаа харамгүй өгч байгаа шүү. Саяын Баасанжаргал гишүүний яг хэлсэн агуулга өнгөрсөн Улсын Их Хурлын танхимд 4 жилийн турш бүх гишүүдийн зүгээс яригдаж дэмжиж ирсэн байдаг юм.

Нэгэнт нэг нь дэмжихгүй, нэг нь дэмжээд ингээд байсан зүйл ерөөсөө байхгүй. Улсын Их Хурал ч тэр, Засгийн газар ч тэр, Сангийн яам ч тэр төсөв хөрөнгийн хувьд үнэхээрийн дэмжсэн. Өөрсдөө цалингаа, батлагдсан цалингаа орон тоондоо багтааж нэмэх боломжийг өнгөрсөн парламентын хаврын чуулганаар мөн хууль баталж шийдсэн. Тэрэнтэй холбоотойгоор шүүгчдийн цалин ажилтнуудын цалин өнгөрсөн хугацаанд 2, 3 дахин өөрчлөгдөөд нэмэгдчихээд байгаа. Одоо гол асуудал юу болж байна вэ гэхээр та бүхэн мэдээлэл өгөхгүй байгаа. Нэг асууж байж нэг юм хэлж байгаа.

Дээд шүүхийн судалгааны академи байгуулж өгсөн. Дээд шүүхийн шүүгчдэд 3 судлаач туслах гаргаж өгсөн. Сүхбаатарын талбайн хажуу талынхаа бие даасан эрх мэдэл гэдэг утгаар нь Хангарди ордныг та бүхэнд өгсөн. Өнгөрсөн онд бид нар энэ Хангарди ордныг засах хөрөнгө оруулалт төсвийг бүгдийг нь шинэ тавилга авч өгөх мөнгийг баталж өгсөн. Мөн би зүгээр энд онцлоод хэлчихье. Монгол Улсын Дээд шүүхийн шүүгчдийг юм үзэж нүд тайлаг гэж бусад бүх газруудын гадаад томилолтын төсвийг хасаж байхад Дээд шүүхэд мөнгө тавьж байсан. Эрс өөрчлөлт гарсан шүү. Энийг үгүйсгэж болохгүй. Ингэж дэмжиж ирсэн. Гэтэл нэг дэмжихгүй байгаа юм шиг бие даасан эрх мэдэлд л нэг халдаад л байгаа нэг юм шиг ийм PR - аа болиорой. Энэ PR-аа харин боль. Нэг юм канондох цаасгүй болчихсон ч юм шиг. Принтергүй болчихсон, суух ширээгүй болчихсон юм шиг энэ яриа хандлагаа харин болиорой. Юмыг бодитойгоор хэлж дүгнэдэг байх ёстой шүү.

Өнгөрсөн 11 сард бас Байнгын хороон дээр үгүй нэг бичгийн цаас ч үгүй болчихлоо гээд л гишүүдээр лобби хийгээд л төсвөө нэмүүлнэ гээд л.

Өнгөрсөн оныхоос шууд 2 дахин нэмчхээд байгаа төсвийн тухай ярьж байгаа шүү дээ. Бүх орон тоонуудыг нь хаа сайгүй хасаж байна шүү дээ. Тэгэхэд яахаараа би хэлээд байгаа шүү дээ ШЕЗ хорин хэдхэн хүнтэй ажлын албатай болоод байхад 100 хэдэн хүнтэй болгочихсон. Тасганы овооны нөгөө шүүхийн байрыг булааж авсан байрандаа багтахдаа больчихсон.

О.Номинчимэг: Одоо санал хураалт.

Улсын Дээд шүүхийн 2026 оны төсвийн төслийн урсгал зардал болон хөрөнгө оруулалтын зардалтай холбогдон гишүүд үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтдаа бэлдье.

Энэ төсвийн тодотголтой холбоотой өмнөх Байнгын хороон дээр энэ төсвөө бас жоохон өөрчилж ир гэсэн чиглэл гарсан боловч төсвийн тодотгол маань бас эцэслэгдэн хэлэлцэгдэж, 2 дугаар хэлэлцүүлэг рүү ч гэсэн арай ороогүй байна.

Дээр нь 2026 оны төсвийг Сангийн яаманд энэ байгууллагууд маань 7 сарын 25-ны дотор бас хүргүүлэх ёстой гэдэг ийм цаг хугацааны асуудал байгаа учраас би тодотголтой ийм саналын томъёоллоор бид нар санал хураалт явуулна.

Улсын Дээд шүүхийн 2026 оны төсвийн саналыг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг тусган улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр хянасныг Улсын дээд шүүхийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

60 хувиар дэмжигдсэн тул санал дэмжигдлээ.

Ажлын хэсэгт баярлалаа

2.ШЕЗ-ийн 2026 оны төсвийн төслийг хэлэлцье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцох ажлын хэсэг, албан тушаалтнуудыг танхимд оруулъя. Хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

ШЕЗ-ийн дарга Мөнгөнцэцэг ирсэн байна, ШЕЗ-ийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Эрдэнэтулга ирсэн байна. ШЕЗ-ийн Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга Наранбилиг ирсэн байна аа.

ШЕЗ-ийн 2026 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг ШЕЗ-ийн дарга Нямсүрэнгийн Мөнгөнцэцэг танилцуулна. Ажлын хэсгийн 3 дугаар микрофон Мөнгөнцэцэг даргын микрофоныг өгье.

Н.Мөнгөнцэцэг: Та бүгдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Төсвийн тодотгол дээр хүртэл бид нартай хамт байж, бид хэд хамтарч, дэмжиж ажилласан та бүхэндээ бас талархсанаа юуны өмнө илэрхийлье. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 33 дугаар тогтоолоор баталсан Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого ШЕЗ-ийн 2022 оны 332 дугаар тогтоолоор шүүхэд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд 2026 оны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсрууллаа. Нийт төсөв 2024 онд 171.1, 2025 онд 329.7 тэрбум, 2026 оны санал нийтдээ 579.2 тэрбумаар орж ирж байна. Энэ нь нийт өмнөх онтой харьцуулахад 76 хувь нэмэгдэхээр урсгал зардал 2024 онд 51.1, 2025 онд 266.8, 2026 оны бид хэдийн оруулж ирж байгаа санал 372 тэрбум буюу 39 хувиар нэмэгдэхээр хөрөнгө оруулалт 2024 онд 19.9, 2025 онд 62.9, 2026 оны санал дээр 207.1 буюу 229 хувь нэмэгдэхээр ингэж оруулж ирж байна аа. Энэний задаргааг танилцуулъя. Цалингийн зардлын тухайд анхан болон давж заалдах шатын шүүхийн шүүгч төрийн өндөр болон төрийн захиргаа, төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин хөлс нэмэгдэл урамшууллын төсөв өмнөх онд 154.2 тэрбум байсан бол 2026 онд 238.1 тэрбумаар төгрөгөөр төлүүлсэн нь өмнөх оноос 54 хувиар нэмэгдсэн байгаа.

Улсын Их Хурлын 2024 оны 5 сарын 30-ны өдрийн 53 дугаар тогтоолоор анхан болон давж заалдах шатын шүүхийн шүүгчийн орон тоог 699 байхаар баталсан бөгөөд уг орон тоонд үе шаттайгаар хүргэхээр зорьсон ба 2026 онд 655 шүүгч ажиллуулахаар цалингийн санг тооцоолсон.

Анхан болон давж заалдах шатын шүүхийн хянан шийдвэрлэж байгаа хэрэг маргаан нь статистик судалгаагаар хэрэг маргааны тоо сүүлийн жилүүдэд дунджаар 25 хувийн өсөлттэй байгаагийн дээр олон оролцогчтой хэрэг маргааны тоо нэлээдгүй нэмэгдсэн. Сүүлийн жилүүдэд шүүхээр хянан шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргааны тоо нэмэгдсэн тул шүүгчийн туслах шүүх хуралдааны нарийн бичиг, эвлэрүүлэн зуучлагч, мэдээллийн технологийн инженер, цахимжуулалт хариуцсан ажилтан, орчуулагч, хэлмэрч, сэтгэл зүйч гэх мэт шүүхийн захиргааны албан хаагчийн орон тоог 437-оор нэмэгдүүлэх ийм шаардлага үүссэн байгаа.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээ нь эдийн засгийн хувьд бусдаас хараат бус ажиллах амьдрахад хүрэлцээтэй, баталгаатай байх боломжийг хангасан байна гэж заасны дагуу шүүгчийн ажлын ачаалал инфляцын түвшинтэй уялдуулан үндсэн цалинг 15 хувиар, зохист ачааллаас давсан ачаалалд Улаанбаатар хот дахь шүүхийн шүүгчид 200 хувиар, орон нутаг дахь шүүхийн шүүгчид 100 хувиар урамшуулал олгохоор төлөвлөлөө.

Цалингийн сантай холбоотойгоор НДШ-ийн зардал мөн нэмэгдсэн байгаа.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын тухайд.

Монгол Улсын шүүхийн улсын хэмжээнд нийт 88 шүүх, 40 шүүхийн Тамгын газар, 40 барилга байгууламжид үйл ажиллагаа явуулж байгаагаас 75 шүүх 35

Шүүхийн Тамгын газар өөрийн байртай ч хуучирч муудсан актлагдсан зай талбай хүрэлцээгүй эрүүл ахуйн шаардлага хангахгүй байранд үйл ажиллагаа явуулж байгаа нь шүүхийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуулийн дагуу явуулах нөхцөл алдагдахад хүргэж байна аа.

Үлдсэн 13 шүүх, 5 Шүүхийн тамгын газар өөрийн байргүйн улмаас түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байна. Нийт байр ашиглалттай холбоотой тогтмол зардал түрээсийн зардалд 15.1 тэрбум төгрөг төсөвлөлөө. Үүнээс байр ашиглалтын зардалд 8.7 тэрбум төгрөгийг төсөвлөсөн болно.

Завхан аймаг дахь шүүх, Баянгол, Хан-Уул, СХД-ийн иргэний хэргийн анхан шатын тойргийн шүүх, Баянзүрх, Сүхбаатар ЧД-ийн иргэний хэргийн анхан шатын тойргийн шүүх, дүүргийн эрүү иргэний хялбар ажиллагааны анхан шатын тойргийн шүүх байр түрээсэлж үйл ажиллагаагаа явуулж байгаа тул шүүхүүдийн байрны түрээсийн зардал 5.1 тэрбум, 2026 оны 1 дүгээр сараас 1 сарын 1-ээс байгуулагдах Гэр бүл хүүхдийн хэргийн давж заалдах анхан болон давж заалдах шатын шүүх нийслэл дэх байранд үйл ажиллагаа явуулахад 3.6 тэрбум төгрөгийн түрээсийн зардлыг төсөвлөсөн.

Хангамж бараа материал, зардлын тухай Дархан болон давж заалдах шатны шүүхээр хянан шийдвэрлэж байгаа хэрэг маргаан өмнөх оныхоос 2025 хувиар өссөн. Иймд 2026 оны төсвийн хязгаарын саналд хангамж бараа материалын зардлын эдийн засгийн ангилалд багтдаг дээрх зардлуудыг хэрэг маргааны өсөлттэй холбоотойгоор өмнөх оныхоос бол 37 хувиар нэмэгдүүлэн төсөвлөсөн байгаа. Норматив зардлын тухайд шүүгчийн нөмрөг нэг бүрийн үнэ 300 мянган төгрөг болж өмнөх оноос 60 хувиар нэмэгдсэн. Шинээр томилогдох шүүгчид нөмрөг хийх учраас өмнөх оноос 37 хувиар нэмэгдэж орж ирсэн байгаа. Эд хогшил, урсгал засварын зардал анхан болон давж заалдах шатын шүүх нийт 88 шүүх, 40 Шүүхийн Тамгын газар 40 барилга байгууламжид үйл ажиллагаа явуулж байна.

Уг барилга байгууламж нь олон жилийн насжилттай иргэдэд үйлчлэх зай талбай муутай, зориулалтын бус байранд үйл ажиллагаа явуулж байгаа. Шүүхийн автомашин тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангахын тулд урсгал засвар хийх шаардлагатай байдаг тул багаж хэрэгсэл, урсгал засварын зардлыг зах зээлийн үнийн өсөлттэй уялдуулан төлөвлөсөн.

Дээрх шүүхийн барилгад шүүх хуралдааны 129 танхим байгаагийн 38 танхимын тавилга сандал ширээг солих болсон. Шүүхээр үйлчлүүлж байгаа иргэдэд зориулсан сандал ширээ эвдэрч цаашид ашиглах боломжгүй болсон. Сэлбэн засах төдий явсаар хэрэгцээ шаардлага хангахгүй болсон тул тавилга эд хогшлийг үе шаттайгаар шинэчлэх ажлыг зайлшгүй хийх шаардлагатай байгаа тул 2026 оны төсөвт 6.1 тэрбум төгрөгийн төгрөгийг тусгасан байгаа. Үүнийг задалбал анхан болон давж заалдах шатын шүүхийн 100 шүүгчийн тавилга авахад 822 сая төгрөг, нийт 300 захиргааны ажилтны тавилга сандал ширээ авахад 1.2 тэрбум төгрөг, 80 Шүүх хуралдааныг танхимын ком тавилга авахад 24 тэрбум, 100 ширхэг архивын нягтруулсан шүүгээ авахад 150 сая, мөн гэр бүлийн шүүх байгуулахад 1 тэрбум төгрөг, хэргийн оролцогч болон иргэдэд үйлчлэх хэсгийн тавилга авахад 500 сая төгрөг тус тус шаардлагатай байна аа.

Анхан болон давж заалдах шатын шүүхэд зориулалтын бус болон түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байгаа ашиглалтын хугацаа дууссан, мөн аюулгүй

байдлыг хангахгүй болсон автомашиныг шүүхийн үйл ажиллагаанд ашиглаж байгаатай холбоотойгоор байнгын арчилгаа тордлогоо шаардлагатай тул 2026 онд зайлшгүй хийх урсгал засварын зардлыг 6.6 тэрбум төгрөгөөр бас төсөвлөсөн байна.

Албан томилолтын зардлын тухайд Монгол Улс өргөн уудам нутагтай онцлог байдлаас хамааран шүүх нүүдэллэн ажиллах, шүүгч өөр аймгийн шүүх хуралдааны бүрэлдэхүүнд оролцохоор томилолтоор ажиллах. Захиргааны хэргийн шүүхийн эд мөрийн баримтын болон газрын үзлэг хийхэд зориулан томилолтын зардлыг төлөвлөсөн байдаг. Мөн ШЕЗ-ийн гадаад харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд мөн тодорхой хэмжээний зардлыг бас төс төлөвлөсөн.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ төлбөр хураамжийн тухайд бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ төлбөр хураамжийн зардлыг тооцоолохдоо шүүхээр хянан шийдвэрлэсэн хэрэг маргааны өсөлттэй холбоотойгоор шинжээч, орчуулагч, хэлмэрчийн зардал, шүүхийн иргэдийн төлөөлөгчийн зардлыг шүүхийн цахим үйлчилгээг хөгжүүлэх хүрээнд шүүхийн архивд хадгалагдаж байгаа урд онуудын хэргийг цахимжуулах шүүхийн кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хийх, төрийн байгууллагуудын хоорондын холбогдох мэдээлэл солилцох интерфэйсийг бий болгох зэрэг асуудлыг тусгасан байгаа. Бараа үйлчилгээний бусад зардал дээр 2026 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн гэр бүл хүүхдийн хэрэг маргааныг шийдвэрлэх анхан болон давж заалдах шатын шүүх байгуулагдах зардлыг бол төсөвлөсөн. Мөн түүнчлэн шүүгчийн чуулган зохион байгуулахтай холбоотойгоор 2025 онд 9.6 тэрбум төгрөгийг төсөвлөсөн байсан бол 2026 онд уг зардал 3.1 тэрбум төгрөг болж буурсан байгааг бас зориуд хэлмээр байна аа.

Тэтгэмжийн зардлын тухайд шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд 14.6 тэрбум төгрөг тэтгэвэр гарахад олгоход нэг олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг анхан болон давж заалдах шатын нийт далан шүүгч 26 тэрбум төгрөг, 18 захиргааны албан хаагч 1.5 тэрбум төгрөгөөр төсөвлөсөн.

Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан олгох мөнгөн тэтгэмжийг нийт 17 албан хаагч 585.1 сая төгрөгөөр төсөвлөсөн байгаа. Мөн ахмадын сан байгуулахад 1 тэрбум төгрөгийг тусгалаа.

Хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга байгууламжийн тухайд Монгол Улсын үндсэн хуулийн 48.3-д шүүх улсын төсвөөс санхүүжнэ. Шүүх үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 74.1.4-д шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах, мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх, олон нийтэд нээлттэй байлгах, аюулгүй байдлыг хангах, стандартад нийцсэн шүүхийн байр, хуралдааны танхим болон бусад барилга байгууламж барих, засвар хийх, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг төлөвлөх зураг төсвийг захиалан боловсруулах гүйцэтгэлийг хангах.

71.1.21-д шүүхийн байрны эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэхээр заасан. Мөн Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд шүүхийг стандартын байр байгууламжаар үе шаттайгаар хангана гэж заасны дагуу шүүхэд зориулалтын бус насжилт өндөр, хуучирч муудсан, иргэдэд үйлчлэх зай талбай багатай нэг ажилтанд ноогдох стандарт шаардлага хангахгүй актлагдсан барилгад ихэнх шүүх үйл ажиллагаа явуулж байгаагаас гадна зарим

шүүх өнөөг хүртэл албан контор торын барилгагүй түрээсийн байранд шүүн таслах ажиллагаа явуулж байгаа нь тулгамдсан асуудал болж байна аа.

ШЕЗ-ийн даргын 2026 онд хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга байгууламжийн төсвийн төсөлд 2025 онд эхлүүлсэн 6 барилга.

О.Номинчимэг: Танилцуулга 10 минутад хийх ёстой. Ерөнхийдөө бусад энэ бүх мэдээллүүд бас бидэнд ирсэн байгаа.

Танилцуулга хийсэн Мөнгөнцэцэг даргад баярлалаа.

Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс ШЕЗ-ийн 2026 оны төсвийн төсөлд хийсэн дүн шинжилгээний талаарх танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн байгаа. Саяын Мөнгөнцэцэгийн даргын танилцуулгад дурдаж байгаа хөрөнгө оруулалтын асуудлууд нэлээн нарийвчилж бас ингээд гаргасан баримт бичгүүд та бүхэн дээр очсон байгаа.

Тэгэхээр ШЕЗ-ийн 2026 оны төсвийн төслийн урсгал зардал болон хөрөнгө оруулалтын зардалтай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Соронзонболд гишүүнээр тасалъя. Аан Ганбат гишүүнээр тасалъя. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя.

Х.Баасанжаргал: Би Хүүхэд гэр бүлийн шүүхтэй холбоотой л асуух гээд байгаа юм. Энэ бол цоо шинэ тогтолцоо. Шинээр байгуулагдах гэж байгаа дагнасан шүүх. Гэхдээ энийг ганцхан шүүх гэж харахгүй байгаа. Тэнд хүүхэд хамгааллын бүхэл бүтэн том цогц үйл ажиллагаа явуулах ёстой гэж харж байгаа. Харамсалтай өнгөрсөн хугацаанд болж байгаа, болсон, саяын энэ гарсан хэргүүд гээд ингээд харах юм бол бид нар ерөөсөө энэ үйл ажиллагааг цогцоор нь харахгүй байгаатай холбоотой. Шүүгч өөрөө бас ажлын ачаалал маш олон нөхцөл байдлаасаа болоод ерөөсөө энэ хохирогч хамгааллын үйл ажиллагаа явагдахгүй байгаа.

Тэгэхээр ШЕЗ-ийн хэд хэдэн төсөв дээр энэ хүүхэд, гэр бүлийн шүүхийн тухай дурдсан байна. Тэгэхээр би бол энэ хүүхэд гэр бүлийн шүүхтэй холбоотой яг ямар ямар зардлууд мэдээж нөгөө байр тоног төхөөрөмжийн зардлууд бас байгаа байх. Түүнээс гадна яг энэ нөгөө хүний нөөцийн зардлуудаа яаж төлөвлөж байгаа вэ? Мэргэжлийн бусад байгууллагатайгаа уялдаж хамтарч ажиллах нөгөө сэтгэл зүйч энэ тэр гээд тэнд маш том ийм дэд бүтэц ажиллах ёстой байгаа. Тэр талаар та бүхэнд яг энэ төлөвлөсөн зардлууд дотор чинь яг аль аль зардал нь илүү тийшээ чиглэж байгаа гэж харж байгаа вэ? Байр тоног төхөөрөмжөөс гадна гэсэн үг шүү тиймээ. Илүү зөөлөн хөрөнгө оруулалтын бодлогыг нь тодруулж байгаа гэсэн үг. Нэг асуулт.

О.Номинчимэг: Гэр бүлийн шүүхтэй холбоотой ажлын хэсгийн 3 дугаар микрофон уу. Мөнгөнцэцэг дарга хариулъя.

Н.Мөнгөнцэцэг: Баасанжаргал гишүүндээ баярлалаа.

2026 оны 1 сарын 1-ээс гэр бүл, хүүхдийн шүүх байгуулахтай холбоотойгоор бид хэд захиргааны ажилтны орон тоогоо нэмэгдүүлэхээр оруулж ирсэн байгаа.

Үүнд бол сэтгэл зүйч эмч, Тамгын газар болгон дээрээ нийт захиргааны албан хаагчийн орон тоог 437-оор нэмэгдүүлэхээр оруулж ирсэн. Үүнээс тал нь ерөөсөө шүүх гэр бүлийн шүүхэд хамааралтай хүмүүс байгаад байгаа юм.

О.Номинчимэг: Бусад байгууллагатай яаж ажиллах юм гээд асуултад.

Н.Мөнгөнцэцэг: Бусад байгууллагатай холбоотой бид нар Гэр бүл, хөдөлмөр нийгэм хамгааллын яамтай холбогдуулаад Баянгол нөгөө зүүн талын бүсийн иргэний хэргийн анхан шатын тойргийн шүүх дээрээ сэтгэл зүйчийг ажиллуулахаар ингээд төлөвлөөд төслийн хүрээнд ажиллаж байна.

Тэгэхээр цаашид бүх шүүхүүд дээрээ энэ сэтгэл зүйчийг орон тоог сая 2024 онд батлагдсан бүтцийн орон тоон дээр оруулж өгсөн байгаад байгаа.

О.Номинчимэг: Хариулт болсон уу? Соронзонболд гишүүн асуулт асууя.

Л.Соронзонболд: Энэ хөрөнгийн зардал дээр байгаа барилгуудаас 2025 оны төсөв дээр тусгагдсан байж байгаад 5 сарын 31-ээр шаардлагаа хангаагүйгээс болж буцсан хэдэн барилга байгаа вэ? 1 дүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт болохоор энэ Дорнод аймгийн шүүх болохоор хуучин ийм сургуулийн дотуур байранд үйл ажиллагаа явуулж байгаа. Байрны шаардлага байна. Шинээр барилга бариулах хэрэгтэй байна гээд хүсэлт гаргаж байсан. Энэ асуудал ер нь танай шүүхийн ерөнхий зүгээс орж ирж байгаа санал дээр байхгүй байна л даа. Тэгэхээр Дорнод аймаг дээр хэзээ төлөвлөж байгаа вэ гэж асууя.

О.Номинчимэг: Ажлын хэсэг 3 дугаар микрофон Мөнгөнцэцэг дарга хариулъя.

Н.Мөнгөнцэцэг: 2025 оны төсвийн 5 сарын 31-ний хэмнэлтийн тухай хуулиар наана нь бол бид 2025 онд төлөвлөгдсөн байсан барилга барих байгууламжийн төсвийн төсөлд эхлүүлсэн 6 барилгын тухайд бүгд татагдаагүй эхлүүлэхээр болсон байгаад байгаа. Цаашид бид хэд харин 2026 оны төсөв дээр нэмээд энэ барилгуудын ажлыг гүйцэтгэлийг дуусгахаас гадна дээр нь нэмээд 8 ийм шүүхэд барилгын асуудлыг барихаар төсөвлөж оруулж ирсэн байгаа. Таны яг асууж байгаа Дорнод аймгийн шүүхийн тухайд бол урсгал засвар дээр засварын ажил бол хийгдэж байгаа. Дээврийн асуудлыг бол шийдсэн, бүрэн шийдсэн байгаад байгаа.

О.Номинчимэг: Соронзонболд гишүүн тодруулъя

Л.Соронзонболд: Яах вэ тэр Дорнод аймгийн шүүхийн одоо үйл ажиллагаа явуулж байгаа байр нь та бүхний яриад байгаа стандарт шаардлагыг хангаж байна гэж үзэж байгаа юм уу л гэж асуугаад байхгүй юу. Миний ойлгосноор болохоор Дорнод аймгийн шүүх бол яг үйл ажиллагаа явуулахад мэргэжлийн стандарт шаардлага хангахгүй байна. Тийм учраас шинээр барилга бариулъя гэдэг хүсэлт тавиад байгаа.

Тэгэхээр та хэд болохоор засвар хийж байгаа гээд байдаг.

О.Номинчимэг: Ажлын хэсэг 3 дугаар микрофон Мөнгөнцэцэг дарга хариулъя.

Н.Мөнгөнцэцэг: Баярлалаа. Харин стандарт шаардлага хангасан барилга бол шүүхийн хэмжээнд нэг ч байхгүй. Харин бид хэд энэ хөгжлийн бодлого батлуулсантай холбоотойгоор энэ барилга байгууламжийн асуудлыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр, шийдвэрлэхээр оруулж ирсэн байгаа.

Тэгэхээр бид хэд энэ шүүхүүдийнхээ байрыг эрэмбэлээд оруулж ирж байгаа учраас Дорнод аймгийн шүүх бол дараагийн удаад орж ирэх нь гарцаагүй. Түүнээс биш стандартын барилгатай нэг ч шүүх одоогийн Монгол Улсын хэмжээнд байхгүй байгаа.

О.Номинчимэг: Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Тэр хүний стандартын шаардлага хангахуйц барилга байгууламж байхгүй байгаа. Ер нь зүгээр энэ шүүн таслах үйл ажиллагаанд бас оролцож байгаа иргэдийн асуудал, сэтгэл зүйн асуудлыг бид бодмоор байгаа юм. Яг зүгээр энэ стандартын барилга байгууламж байхгүй учраас тэр давчуу зайн дээр яг нөгөө хариуцагчийнхантайгаа ч юм уу өөдөөс хараад суудаг. Эсвэл эрүүгийн хэрэг дээр бол шүүгдэгчтэйгээ өөдөөс маш ойрхон зайнд ч гэдэг юм уу ингээд нүүр тулаад л явдаг сэтгэл зүйн хувьд ч гэсэн хүнд.

Тэгэхээр ер нь зүгээр яах вэ шүүхийн үйлчилгээг иргэдэд ойртуулах сэтгэл зүйн тэр хэрэг маргаанаа бас нэг таатай уур амьсгалд гэдэг юм уу таатай гэж юу юм хэрэг маргаан явна гэж байхгүй л дээ. Тэгэхдээ ер нь зүгээр ядаж ариун цэврийн 00-той, хүн бас нэг сэтгэл зүйгээ засах тэр орон зай энэ тэр байх ёстой байгаад байгаа юм аа. Энийг нь ойлгож байгаа юм. Тэгэхдээ би нэг зүйлийг бас Шүүхийн ерөнхий зөвлөлдөө хандаж хэлмээр байна. Бас Мөнгөнцэцэг даргын асуудал биш л дээ. Саяхан томилогдсон. Түрүү жил яг энэ өдийд төсөв баталж байхад Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар дарга бид 2 Сангийн сайдтай, Сангийн яамтай энд марган марган бараг 30 хэдэн тэрбум билүү дөчөөд тэрбумаар юмыг нь тавиад өгсөн. Сая буцаагаад 65-ыг нь татуулчхаж байгаа юм. Тэгээд ажлын хэсэг дээрээс буцаад 12 нь тавигдаж байх шиг байна.

Ер нь ингээд энэ тавьж өгсөн хөрөнгө оруулалтуудыг тендер худалдан авалтаа зохион байгуулж чадахгүй татуулчхаад байгаа байхгүй юу. Тэгэхээр бид хэд бас Улсын Их Хурлын Улсын Их Хурлын энэ өгч байгаа бас боломжийг бас хууль тогтоомжийн хүрээнд зөв зохион байгуулах ажил бас хангалтгүй байгаад байгаа шүү. Энийг бас анхаараач.

Улсын Их Хурлын гишүүд ч мөн шүүх эрх мэдлийн байгууллагад нэг их таагүй хандаад байгаа зүйл байхгүй. Аль бололцоотой бүх зүйлээрээ дэмжиж байгаа. Өгч байгаа энэ боломжийг бас хэрэгжүүлэх зохион байгуулалтын ажлууд хаа хаанаа бас учир дутагдалтай байгаа нь сая төсвийн тодотголоор харж байна. Ерөөсөө тендерээ зарлаж чадаагүй буюу зохион байгуулж чадаагүйгээс 65-ыг нь татаж байгаа гэж байгаа байхгүй юу. Ийм зүйлүүд байгаа шүү. Тэгээд ер нь зүгээр мэдээж улс эх орны эдийн засаг дандаа ийм юм байхгүй байх. Энийг аль болохоор ингээд бас нэг ачаалал багатайгаар энэ асуудлуудыг цаашдаа шийдээд явах байх. Энэ итгэл үнэмшил дээр ч гэсэн гишүүд маань байгаа. Энийг бас та бүгддээ хэлмээр байна. Тэгээд зүгээр ер нь ярьж байгаа нэг зүйл байна. Мэдээж энэ цахимжилтын бодлогыг би дэмжинэ. Эргээд бас шинэ Хууль зүйн сайдад хэлсэн байгаа. Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын Цахимжилтыг дэмжих тухай хууль гаргаж

ирж энэ үүсэж байгаа хатуу болон зөөлөн дэд бүтцийг дундаа шэйрлэж ашиглах байдлаар явахгүй бол шүүхүүд нь нэг баахан тоног төхөөрөмж, прокурорууд нь баахан тоног төхөөрөмж, мөрдөх энэ тэр ч гэдэг юм уу ингээд ийм юмнууд байгаа учраас энэ зүйлүүд дээр хэдүүлээ нэг бас нэг зөв төлөвлөгөө гаргаж ажиллах ёстой шүү. ШЕЗ Энэ дээр бас манлайлал үзүүлж ажиллаасай гэж би хүсэж байгаа юм.

Тэгээд эцэст нь яах вэ зүгээр энэ төсвийг бол дэмжээд явна нэг зүйл байна. Цаашдаа энэ хүний нөөцийн асуудлыг тогтоох энэ орон тооны дээд хязгаарыг тогтоохдоо 3 засаглал нэмэх нь нэг асуудлыг би ер нь онцгой анхааръя гэж бодож байгаа юм. Юу вэ гэхээр гүйцэтгэх засаглал ямар тоо хэмжээтэй явах юм, яаж тогтоодог байх юм гээд. Сайнзориг гишүүн нэг минут.

Шүүх эрх мэдлийн засаглал, тэр дундаа цэц байгаа, прокурор байгаа. Энэ байгууллагуудын орон тоог ямар аргачлалаар тогтоох юм? Дээрээс нь Улсын Их Хурлаас байгуулагддаг байгууллагуудын асуудлуудыг яаж бас тогтоох юм? Огтоосоо хяналтгүй бие даасан гэдэг статусыг хэт бас туйлшруулж хэрэглэдэг.

Монголбанкнаас эхлээд яаж хязгаарлах ёстой юм? Дээрээс нь бид хэдийн нэг анхаарах юм нь нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудыг бас бие дааж юмаа шийддэг. Энэ дээр нэг ажлыг жишээ нь 3 хүн хийдэг болчихсон. Энэ хавтгайдаа болсон.

Тэгэхээр ийм зүйлүүдийг цаашдаа нэг ийм ултай суурьтай яг тогтоож аргачлалыг нь тогтоогоод энийгээ 1 тэгшитгэж дараа нь ингээд эрх мэдлүүд рүүгээ халдахгүйгээр бас бодлогоо барьдаг заалтыг судалж нэг энэ намрын чуулганаар бас хууль эрх зүйн орчныг бүрдүүлье гэж би бодож байгаа.

Тэгээд энэ дээр бас ер нь зүгээр яах вэ манай Хууль зүйн байнгын хороо л жоохон манлайлж ажиллах шаардлага харагдаад байгаа. Би бас гишүүддээ энийг тэгээд бас уриалж байгаа юм шүү. Шаардлагатай бол хэдүүлээ дотроо ингээд ажлын хэсэг гараад ингээд бас нэг шийдээд энийг цэгцлэхгүй бол тэгшитгэж хасаад л.

Тэгээд л бид хэд нэг шүүх эрх мэдлийн байгууллага хайргүй ч юм шиг.

О.Номинчимэг: Санал юм байна тиймээ. Сайнзориг гишүүн ялангуяа тэр шүүхийн цахимжилттай холбоотой, хөрөнгө оруулалтаа хугацаанд нь хийхтэй холбоотой маш чухал бас саналууд хэллээ.

Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууя.

Д.Ганбат: Сүүлийн 3, 4 жил улсын төсөв бараг 2 дахин нэмэгдсэн. Яах юм асуулт байгаа юм уу Сайнзориг гишүүн ээ? 2 дахин нэмэх зүйл дээр ШЕЗ ер нь ямаршуухан байгаа билээ? Уг нь та нар чинь хуульд заасныхаа дагуу л тэр шүүхийн хараат бус ажиллуулах, шүүх шударга байх тэр нөхцөл боломжийг л хангах ийм л байгууллага шүү дээ. Тэгээд тэр ажлаа хийж чадаж байна уу? Чадахгүй байна уу? Тэр ажлыг хийхэд одоо хууль, эрх зүйн орчин чинь таарахгүй байна уу? Эсвэл та бүхний байгаа байдал чинь ийм байна уу гэсэн ийм асуулт байх юм. Тэгээд энэ чинь янз бүрийн үлдэгдлээр санхүүжих гэж байгаа юм шиг бас нэг гуйлгын чанартай яваа юм шиг иймэрхүү юм байж болохгүй л дээ.

Тэр хуулийн зүйл заалт байсаар байхад тэр хуулийнхаа зүйл заалтын дагуу л явж баймаар юм. Тэгээд ШЕЗ-өөс тэр мөнгө төгрөгийг нь хасах шаардлага энэ тэр юунаас ургаж гардаггүй юм. Шүүхийг мөнгө санхүүгүй байлгаж байж бас ийм ядруу байдалтай байлгах нь хэнд ашигтай юм. Улс орны нөхцөл байдал хүнд байгаа нь байгаа л даа. Гэхдээ шударга шүүх байгаад дээр нь гадаадын хөрөнгө оруулалт байвал энэ улс орон цаашаа явчихна л гээд байгаа шүү дээ. Ийм л байгаа. Гэтэл та нар тэр шүүхийн ажил хийх нөхцөл боломжоор хангахгүй байна уу? Эсвэл шүүх нь угаасаа ийм авлигад идэгдсэн ийм байна уу? Ер нь шүүх хараат бус байдлаар ямаршуухан байдалтай байгаа вэ.

Тэр гадна, дотнын байгууллагын эд зүйлд барьдаг дүн мүн гээд хэдэд байна. Авлигатайгаа тэмцэж барьж байгаа юм байна уу гэсэн ийм асуудлууд байна.

Хамгийн наад зах нь гэж шүүхийн байрны шаардлага хангах нэг ч тийм шүүхийн байшин байхгүй байна гэж байна шүү дээ. Шүүх чинь хэдэн жилийнхээ ойг хийж байгаа билээ дээ ийм байж болох уу? Тэгээд л бүгдээрээ л шүүхийг харцгаа яаж шийдэх юм гээд л ингэдэг. Тэгээд шүүх нь шийддэг л дээ. Тэр үед 30, 40 тэрбумыг идчихсэн нөхдүүдийг 20, 30 саяар торгоод л гаргаж байх жишээтэй. Тэгэхээр ийм болохоор ард түмэн бүүр дургүй хүрээд байгаа байхгүй юу. Тэгээд та нар тэр Улсын Дээд шүүх дээр л их анхаарал тавьсан юм байна л даа. Тэр сургалт судалгааны байгууллага ШЕЗ дээр байх нь зөв юм уу эсвэл Улсын дээд шүүхтэй байх ёстой юм уу? Танайхан юу гэж үздэг юм? Би бол тэр шүүн таслах ажлаа Улсын дээд шүүх нь хийгээд шүүгчид нь хийгээд энэ эдийн засаг, засаг захиргааны ажил, тэр гадаад томилолт энэ тэрээ бол ШЕЗ нь хариуцаад явдаг байх ёстой л гэж ойлгоод байгаа шүү дээ. Тийм юм чинь хэзээ гажуудчихсан юм бэ? Тэгээд нэг Улсын дээд шүүх нь орж ирээд төсвөөр наймаалцаж байдаг мөнгө төгрөгөөр шударга ёс цаана нь хаана юу болоод үлдээд байгаа юм?

Тэгээд ШЕЗ-д хангах ёстой улсууд нь дув дуугүй байгаад байдаг. Тэгээд Сахилгын хороо гээд байгууллага байж байна Үндсэн хуулийн. ШЕЗ гээд байгууллага байж байна. Тэр нь нэг нь 4 жилээр, нэг нь 6 жилээр юм билээ. Уг нь адилхан байгууллага адилхан.

О.Номинчимэг: Ажлын хэсэг 3 дугаар микрофон. Мөнгөнцэцэг дарга хариулъя.

Н.Мөнгөнцэцэг: Ганбат гишүүнд баярлалаа.

Үнэхээр бодлогын шинж чанартай, яг тулгамдсан, яг гол гол асуудлуудыг хөндөж ярьж асууж байгаад үнэхээр талархлаа илэрхийлье ээ. ШЕЗ-ийн эдийн засгийн шүүхийн эдийн засгийн баталгааг хангах төрийн үүрэг байгаад байгаа юм. 2021 онд бол шүүхийн төсөв 61.1 тэрбум, 2022 онд 79.2, 2023 онд 94.4, 2024 онд 171.5, 2025 онд бол 329.8 тэрбумаар батлагдсан. Өөрөөр хэлбэл улсын төсөвт бол нийт эзлэх 0.38 хувь байсныг яг 1.2 хувь болгож өссөн. Та бүхний баталж өгсөн шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогод 2-оос доошгүй хувийг улсын төсвийн нийт төсвийн 2-оос доошгүй хувийг шүүхийн төсөв байна гэж батал юу яаж баталсан?

Тэгээд үүнтэйгээ уялдуулаад энийг бол үе шаттайгаар цаашид хэрэгжүүлнэ гэдэгт бид бас бүхэн итгэлтэй байна аа.

Хоёрдугаарт шүүхийн академи бол бас хаана байх ёстой вэ гэдгийг бас та бас тодотгож асууж байна. Үүнтэй холбоотойгоор шүүхийн захиргааны байгууллага ШЕЗ 2013 оноос хойш бие дааж хараат бусаар үйл ажиллагаагаа явуулж байна. Ингэж ирэхдээ бол 1992-2002 он хүртэл бол Хууль зүйн яамны дэргэд, 2002-2012 онд бол Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгч, ШЕЗ-ийн даргыг хавсарч гүйцэтгэдэг байсан. 2013 оноос ийнхүү бие даагаад 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бол ШЕЗ нь Үндсэн хуулийн байгууллага болж өөрчлөлт зохион байгуулагдсан байгаад байгаа.

Үүний нэгэн адил шүүхийн академи бол анх Дээд шүүхийн дэргэд байсан. Дараа нь ШЕЗ-ийн дэргэд 2013 оноос 2021 он хүртэл байж байгаад одоо Улсын дээд шүүхийн дэргэд бол Шүүхийн академи маань үйл ажиллагаагаа явуулж байна аа. Тэгэхээр ШЕЗ адил, шүүхийн академи ч гэсэн ялгаагүй. Энэ загваруудыг бол туршиж үзэж байна. Яг эцсийн байдлаар бол ШЕЗ-д зөвлөлийн дэргэд Шүүхийн академи маань байхад хэт онолын сургалтууд их яваад байна. Практик сургалтаасаа холдлоо гэсэн энэ шалтгаанаар бол ер нь ШЕЗ-ийн дэргэд байсан сургалтыг Дээд шүүх рүүгээ хажууд нь аваачсан. Тэгээд одоо энэ харагдаж байгаа үйл ажиллагаа юунаас бас хаанаа байх ёстой вэ гэдгийг энэ 2 туршилтаас бас эцсийн байдлаар дүн гарахад бас шууд хэлэхэд бас эрт байна гэж харж байна.

Хоёрдугаарт шүүхийн академи бол Шүүхийн академийн үйл ажиллагаанд ШЕЗ хэрхэн оролцож байна вэ гэхээр бид нар бол шүүхийн сургалт сургалтын хөтөлбөр хороонд нь ажилладаг. Сургалтын хөтөлбөрийг бол ШЕЗ-ийн хуралдаанаар хэлэлцдэг байсныг 2024 оны Шүүхийн тухай хуульд өөрчлөлт орсноор шүүгчийн сургалт бол тэр чигтээ Улсын дээд шүүхэд харьяалалд очсон. ШЕЗ-ийн тухайд бол хүний нөөцийн удирдаж байгаагийн хувьд шүүгчийн сургалт уг нь манай дээр бас тодорхой хэмжээгээр харьяалагдах байх ёстой байтал 100 хувь бол Дээд шүүхийн харьяалалд очсон гэдгийг бас зориуд хэлмээр байна аа.

Гуравт шүүх бие дааж хараат бусаар ажиллаж байна уу? Гарч байгаа шүүхийн шийдвэр нь өөрөө үндэслэлтэй шударга ёсонд нийцэж байна уу гэж бас асууж байна.

ШЕЗ бол шүүгчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, шүүхийн бие даасан хараат бус байдлыг хамгаалах ийм байгууллага байгаад байгаа. Тэгэхдээ шүүхийн хараат бус байдлыг хангах ёстой. Шүүгчийг хамгаалах ёстой гээд шүүгчийн хариуцлагыг бол мэдээж хариуцлага бол энэний ар талд нуугдах ёсгүй.

Тэгээд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Сахилгын хороо бол байгуулагдсан байгаад байгаа.

Тэгэхээр шүүхийн эрх мэдлийн байгууллагын тулгуур 3 байгууллага буюу Улсын дээд шүүх, ШЕЗ, Сахилгын хороо гэсэн энэ байгууллагууд ажлаа уялдуулж зөв гэх юм уу хуульд заасан.

О.Номинчимэг: Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Та нар наад юмаа яг нэг болгоорой яг ямар учиртай юм. Тэгээд 1 бөөрөнхий л хариулт хэлээд байх юм. Та нар тэгээд судалгаа энэ тэр хийдэг юм бол аль талдаа байх ёстой нь юм. Баймаар байх ёстой шүү дээ тийм. Одоо тэгээд олон улсын гаргаж байгаа судалгаа шинжилгээгээр Монгол Улсын шүүх, шүүх засаглал

ер нь хараат бус байж чадаж байгаа юу? Хэдэд нь байгаа вэ? Тийм байгууллагын дүгнэлт энэ тэр байдаг уу гэсэн ийм асуулт би асуугаад байна л даа.

О.Номинчимэг: Индексийн талаар тодорхой асуулт байна. 3 дугаар микрофон Мөнгөнцэцэг дарга.

Н.Мөнгөнцэцэг: Өмнөх Байнгын хорооны хурал дээр бас асууж байсан. Тэгээд ганцхан шүүхийн индексийн үнэлгээ шүүхэд тавьж байгаа ганц үнэлгээ гэж би ойлгохгүй байна. Энэ угаасаа нөгөө төр засаг нийгэмд хүмүүсийн хандлага ямар байна вэ ямар үнэлгээ тавьж байна вэ гэдэг бол угаасаа шүүх төр засаг бид та бид бүгдийн хамтын л үнэлгээ гэж харж байгаа. Хэрвээ энэ индекс буурч байгаа бол зөвхөн шүүхийн асуудал биш ээ. Энэ бол та бүгдийн бид нарын ерөөсөө хууль тогтоох байгууллага, гүйцэтгэх байгууллага, шүүх эрх мэдлийн хамтын энэ үнэлгээнд тавьж байгаа энэ иргэдийн үнэлгээ л гэж би бол миний хувьд харж байгаа. Тэгээд цаашид хамтарч ажиллах ажлаа улам уялдуулж ойлголцох шинэ шат нь гарах ёстой гэдгийг бүүр дахин дахин хэлмээр байна. Тэгээд хамгийн гол нь бид нар 2024 онд Хөгжлийн бодлогоо шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого буюу алтан гадсаа батлуулж чадсан учраас энэ рүү энэ чиглэлд энэ ерөөсөө л.

О.Номинчимэг: Нөгөө Нээлттэй нийгэм хүрээлэнгээс уг нь 2 жил тутамдаа шүүхийн хараат бус байдал, шүүхийн ил тод байдалтай холбоотойгоор индексээр тодорхой үзүүлэлтүүдээр уг нь нэг гарч байгаа шүү дээ. Ямар үзүүлэлт нь сайжирч байгаа юм ямар үзүүлэлт нь унаад байгааг уг нь тодорхой хэлсэн бол гэж бодож байна. Төсвийн урсгал зардал болон хөрөнгө оруулалтын зардалтай холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

ШЕЗ-ийн 2026 оны төсвийн төслийн урсгал зардал болон хөрөнгө оруулалтын зардалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Баасанжаргал гишүүнээр тасаллаа. Ирцийн дагуу Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: За байз 2 юм хэлье.

Нэгдүгээрт би хөндсөн гэр, бүл хүүхдийн шүүхийн асуудлыг энэ өөрөө маш хариуцлагатай шүүх бөгөөд захиргаа бид нар бүгдээрээ санаж байгаа шүү дээ. Захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулах гэж ямар их бэлтгэл хангаж ямар том цогц систем ингэж бид нар бий болгож чадлаа гээд. Гэр бүл, хүүхдийн шүүх бол энэнээс илүү өргөн хүрээтэй бөгөөд бүх хүний ахуй амьдрал ялангуяа хүүхдүүдийн амьдралын чанарт нөлөөлөх ирээдүйд маш чухал ийм механизм байгуулагдахаар хууль нь батлагдсан. Тэгээд үүнийг хэрэгжүүлэхдээ ухамсартайгаар одоо ерөөсөө яг нэг Гэр бүлийн яамыг хамтын ажиллагаатай ч гэдэг юм уу нэг ийм ерөнхий байдлаар дээрээс нь зөвхөн сэтгэл зүйчийг бий болгосноороо энэ бүхнийг хангачихна гэж ерөөсөө харж болохгүй. Энэ маш том цогц үйл ажиллагаа байгаад байгаа. Маш олон орны судалгаанууд хийгдчихсэн. Зөндөө олон улс орнууд энэ дагнасан шүүхийг бий болгосон. Энэ нь өөрөө хүний нөөцийн маш том дэд бүтэц бий болох ёстой гэдгийг бид нар маш сайн ухамсарлах ёстой. Яг одоогийн байгаа шүүхийн загвараар энэ ерөөсөө яг энэн шиг ийм шүүх байх ёсгүй. Тэгээд энэ дээр манай ШЕЗ, Улсын Дээд шүүх аль аль нь хамтарч ажиллаж, манлайлж бүр энэ асуудал дээр бүр онцгой анхаараад өгөөч гэж би бүр ёстой чин сэтгэлээсээ гуйя аа.

Тэгээд ёстой бусад тэр Хөдөлмөр, нийгэм, хамгааллын яам өөр бусад оролцох ёстой, хамтрах ёстой байгууллагууд нь хамтарч оролцохгүй байгаа бол энэ

асуудал дээр яах ёстой байдаг юм тэ? Ажлын хэсэг эсвэл түр гаргах юм уу? Яах вэ гээд энэ дээр манай ХЗБХ ч гэсэндээ бас энэ дээр ер нь жаахан анхаарч өгөх ёстой байх аа. Тэгэхгүй бол ерөөсөө бид нар энэ яг одоогийн байгаа процессын хуулиараа, яг одоогийн байгаа гэрч, хохирогч хамгаалж байгаа байдлаараа энэ шүүх байгуулагдаад ч бид нар энэ эрсдэлийг бууруулж чадахгүй. Тэгэхээр энэ дээр бүүр хүний нөөцийн хувьд ч гэсэндээ бид нар маш онцгой анхаарч бүүр загварыг маш сайн боловсруулж аягүй сайн гаргах ёстой байгаад байгаа юм. Тэгээд би энэ дээр зориуд энэ ирэх жил тэр шинэ шүүх байгуулагдах гэж байхад хүний нөөцөө зөөлөн дэд бүтцээ яаж харж байна вэ гэж л энэ тоон дээрээс харах гээд байгаа байхгүй юу.

Мэдээж тэр том чиг үүрэг чинь бас л төсөв мөнгөний асуудал яригдана шүү дээ тэ? Тэгэхээр энэ дээр яг одоогийн байгаа энэ бид нарт ирүүлж байгаа танилцуулгын хүрээнд бол их л жаахан тааруухан л үйл явц жаахан тааруухандуу л явж байна уу л гэж харах гээд байна аа. Тэгэхээр энэ дээр бас анхаараарай гээд.

Хоёрдугаарт тэр дотоод бүтцийн асуудал ШЕЗ, Улсын дээд шүүх, Сахилгын хороо хэн нь ямар эрх мэдэлтэй байх, судалгааг нь хэн нь хийх, сургалтыг хэн нь хийх. Яг үнэндээ иргэдэд энэ ёстой ямар ч хамаа байхгүй. Та нарыг бүгдээрэнг нь нийлүүлээд л шүүх эрх мэдэл гэж харж байгаа шүү дээ. Тэгээд 1 ийм байдалтай нэг салбарын дотоод нэг ийм явцуу эрх ашиг сонирхолдоо хөтлөгдсөн байдлаар ингэж асуудалд битгий хандаач. Яг үнэндээ ингээд л Хууль зүйн байнгын хорооны гишүүд бүгдээрээ энэ хууль шүүхийн байгууллагыг маш сайн ойлгодог маш сайн дэмжих Энхбаяр гишүүний санаачилсан санаачилга маш сайн суурь нь тавигдаж үргэлжилж байгаа гэж би хувьдаа харж байгаа юм.

Гэтэл шүүх эрх мэдлийн байгууллагынхан маань өөрсдөө ингээд нэг ийм хандлага нь дотоодын нэг ийм явцуу ашиг сонирхол нь түрүүлж гарч ирээд энэ нь ерөөсөө аягүй хэцүү аягүй урам хугалах юмаа нээрээ. Тэгэхээр энэ дээрээ бүр ер нь нэг бүгдээрээ нэг ийм нухацтай яримаар байна. Түрүүн Соронзонболд гишүүн асуусан. Дорнодын шүүх хэзээ баригдах юм бэ гээд. Яг энэнийг чинь ингээд урт хугацаагаар нь бид нар хармаар байгаа байхгүй юу. 4, 5 жилээр нь хармаар байгаа байхгүй юу. Тийм мэдээллийг нь Хууль зүйн байнгын хорооны гишүүдэд өгөөд өгөөч л гэж хүсээд байгаа гэсэн үг. Мэдээж энэ нөгөө бодлогын баримт бичгийн хүрээнд энэ бүх юм чинь явж байгаа байх аа. Тэгэхээр энэ зүйлүүд дээрээ бас анхаараасай гэж хүсэж байна. Тэр индекс үзүүлэлтийн хувьд бол хариуцлагаас бас битгий ийм зайлсхийсэн хариулт цаашид өгөөрэй л гэж хүсье дээ. Баярлалаа. Амжилт хүсье.

О.Номинчимэг: Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн үг хэлье.

Х.Тэмүүжин: Эхнийх нь болохоор тэр Гэр бүл, хүүхдийн шүүхтэй холбоотой асуудал дээр Улсын Их Хурлын гишүүд, ШЕЗ дээд шүүх нэг Япон яваад Токиогийн гэр бүлийн шүүхийг очоод үзчих хэрэгтэй байх. Хүмүүс нь ирсэн юм уу? Би 2014 онд Хууль зүйн сайд байхдаа Токиод очиж тэр шүүхийг үзсэн юм.

Тэр шүүх бол ерөөсөө л нэг тийм яг гэр бүл, хүүхдэд зориулсан их дэлгүүр шиг юм байна лээ. Хүүхдээ хамгаалах өрөөтэй, эвлэрэн зуучлах системтэй гээд ерөөсөө бүхэл бүтэн систем байгаа байхгүй юу. Тэгээд гэр бүлийн хүчирхийлэл юм уу янз бүрийн юм хөндөх юм бол хонуулах байртай гэх мэтчилэн ингээд цогц юм байна лээ. Тэгээд тийм хэмжээний өөрчлөлт хийхийн тулд төсөв хэрэгтэй байх.

Гэхдээ ойлголт хэрэгтэй байх. Очоод нэг харах тийм юм хийх байх. Саяын тэр ШЕЗ дээр болон Дээд шүүхийн хооронд маргаад байгаа академ тэр сургалт хаанаа байх, судалгаа хаанаа байх гэдэг чинь ингээд буруу ойлголт хэт хавтгайрч тэгээд амбиц явснаасаа болоод ингээд зөрчилдөөн үүсээд байгаа байхгүй юу. ШЕЗ-ийг үндсэн 2 чиг үүрэгтэйгээр 2012 оны өөрчлөлтүүдийн хүрээнд хийсэн шүү дээ.

Мэдээж хэрэг Үндсэн хуульд заасан байгаа хуульчдаас шүүгчийг сонгон шалгаруулах тэр чиг үүргийг хэрэгжүүлж байгаа.

Хоёрт нь шүүхийн захиргааны үйл ажиллагаа. Яагаад гэвэл шүүх бие даасан хараат бусаар ажиллахын тулд захиргааны дэд бүтэц өөрөө хүртээмжтэй байж байж нөгөө энэ Үндсэн хуульд заагдсан хараат бус бие даасан байдал хангагдах учраас энэ захиргааны чиг үүрэгтэй нь холбогдуулж ШЕЗ-ийн чиг үүргийг өргөтгөсөн юм. Сургалт бол шүүгч нарт сургалт хийх эрх мэдэл та нарт ерөөсөө байхгүй. Шүүгч нарт сургалт хийх эрх мэдлийг дээд шүүгчидтэй булаацалдаж амбицлах ерөөсөө хэрэг байхгүй байхгүй юу. Шүүхийн захиргааны алба хаагчдаа мэргэшүүлэх шүүн таслах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх тэр дэд бүтцийг нь сайжруулах зорилготой сургалтаа та нар хийх ёстой байхгүй юу. Тэр чиглэлийнх нь судалгаагаа та нар хийх ёстой байхгүй юу.

Тэгсэн чинь тэр Лүндэндорж багшаас авхуулаад цаашаа юу болоод явчихсан гэсэн чинь шинжлэх ухааны судалгаа болгож хувиргаад шүүгчид рүү сургалт хийх чиглэл рүү оруулчихсан. Тэр алдаа чинь дотоод нэг тэр амбицын зөрчил рүү оччихсон байхгүй юу. Одоо тэрийгээ таслан зогсоогоод болиод Дээд шүүхдээ шүүгчдийн сургалтыг булаацалдаж ерөөсөө болохгүй шүү дээ. Та нарт тийм чиг үүрэг байхгүй. Томилогдсон л бол тэр шүүгч та нараас үл хамааралтай. Та нар тэр шүүгчдийг яаж ажиллах, ямар мэдлэгтэй байх, ямар ур чадвартай байхыг нь хэмждэг хүмүүс ерөөсөө биш. Тэгээд энийг ойлгох ёстой. Дээд шүүхэд яагаад энэ сургалт академи байгаа юм бэ гэхээр дэлхий нийтээрээ Дээд шүүх гэдэг чинь онолын шүүх. Хуулийн хэрэглээний нэгдсэн стандартыг шүүхийн практикт тогтоодог тэр шүүх нь.

Тийм учраас хуулийн хэрэглээний нэгдсэн практик тогтоохын тулд тэр шийдвэр гаргалтдаа судалгаатай хандах нь Дээд шүүхийн бүр үүрэг байхгүй юу. Дээд шүүхэд дэлхий нийтээрээ яагаад энэ судалгааны дэд бүтэц хүчтэй байдгийн гол шалтгаан нь зүгээр л анхан давж заалдах шат гэх мэтчилэн шүүхийн нэгдсэн практик дээр хуулийн зөв хэрэглээ тогтооход хангалттай их судалгаатай байх хэрэгтэй.

Хоёрт нь тэр тогтоож байгаа практик хэрэглээгээ шүүгч нарт мэдлэг болгож дамжуулах ёстой. Тийм учраас дээд шүүх дээр энэ сургалт нь байж байх ёстой шүүгч нартай холбоотой сургалт нь, судалгаа нь байж байх ёстой. Зүгээр дээд шүүх өмнө нь ямар ажил хийгээд байсан бэ гэхээр Дээд шүүх захиргааны арга хэрэгслээр доод шатных нь шүүгч нартай нь нөлөөлдөг байсан юм. Тэрийг таслан зогсоохын тулд ШЕЗ-д энэ захиргааны чиг үүргийг Дээд шүүхээс салгаж авч өгсөн байхгүй юу. Энэ 2-ыг ялгаж зааглах ёстой шүү. Дээд шүүхийнхэн бас андуураад байх шиг байна лээ.

О.Номинчимэг: Тэмүүжин гишүүн нэг минут.

Х.Тэмүүжин: Дээд шүүх хууль тайлбарладаггүй. Үндсэн хууль дээр маш тодорхой байгаа. Их андуу ойлголт манай хуульчдын дунд байдаг юм байна лээ. ҮХЦ дээр ч гэсэн энэ маргаан явж байсан. Үндсэн хууль дээр ямар үг байгаа вэ гэхээр Дээд шүүх хууль зөв хэрэглэх талаарх албан ёсны тайлбар гаргана. Хууль тайлбарлах биш. Хууль зөв хэрэглэх талаар. Яагаад Үндсэн хууль дээр ингэж бичсэн бэ гэхээр хууль тогтоох эрх мэдэл Улсын Их Хуралд байгаа. Хууль биелүүлэх эрх мэдэл, гүйцэтгэх эрх мэдэлд байгаа. Хууль хэрэглэх эрх мэдэл шүүхэд байгаа. Бүх шүүх хуулийг зөв хэрэглэж байна уу үгүй юу гэдэг тал дээр тайлбар хийх эрх мэдэл нь Үндсэн хуулиараа Улсын дээд шүүхэд байгаа.

Тэгэхээр хэрэглээний тайлбар гаргадаг гэдгээ ойлгохгүй. Хууль тайлбарлаж байна гэх юм бол энэ алдаа болно. Хууль тайлбарлах эрх бол бүх хуульчдад байгаа. Хуульчдын лицензийн 1 дүгээр эрхийг бол хууль тайлбарлах эрх гэж хэлдэг юм байна лээ. Хуулийг албан ёсоор хууль дотроо тайлбарлах эрх нь бол Улсын Их хуралд байгаа. Хууль батлах явцдаа. Энэ ялгаануудыг бид нар.

О.Номинчимэг: Төсвийн төсөл төслийн урсгал зардал болон хөрөнгө оруулалттай ШЕЗ-ийн 2026 оны төсвийн урсгал зардал болон хөрөнгө оруулалтын зардалтай холбогдуулан гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү.

Мөн түрүүний адил тодотголын төсвийн тодотгол явж байгаатай холбоотойгоор тодотголтой саналын томъёоллоор санал хураана.

ШЕЗ-ийн 2026 оны төсвийн саналыг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг тусгасан хувилбарыг улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр хянасныг ШЕЗ-ийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явъя.

Санал хураалт.

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Ажлын хэсэгт баярлалаа.

11.26 цаг

Дараагийн асуудалд оръё. 3 дахь байгууллага буюу [Шүүхийн сахилгын хорооны 2026 оны төсвийн төслийг хэлэлцье ээ.](#)

Ажлын хэсгийг танхимд оруулъя.

Шүүхийн сахилгын одоо оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Шүүхийн сахилгын хорооны дарга Ариунтуяа дарга ирсэн үү ирсэн байна. Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны дарга Мөнхзориг ирсэн байна. Шүүхийн сахилгын

хорооны Санхүү төсөв хөрөнгө оруулалт хариуцсан ахлах референт Ерөнхий нягтлан Ариунжаргал оролцож байна аа.

Шүүхийн сахилгын хорооны 2026 оны төсвийн төслийн талаар танилцуулгыг Шүүхийн сахилгын хорооны дарга Доржгочоогийн Ариунтуяа танилцуулна. Ариунтуяа даргад микрофоныг өгье.

Бид нарт Улсын Их Хурлын тамгын газраас нэлээн нарийвчилсан дүн шинжилгээ хийсэн баримт бичгүүд бас тараагдсан байгаа учраас та танилцуулгаа болж өгвөл богинохон болгоод танилцуулж өгнө үү. 3-аас 5 минутад.

Д.Ариунтуяа: Ойлголоо. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Шүүхийн сахилгын хороо Монгол Улсын Үндсэн хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд Шүүхийн тухай хуулийг хэрэгжүүлж, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд хүндэтгэлтэй хандахын зэрэгцээ хуульд заасан шүүгчийн сахилга хариуцлагатай холбоотой асуудалд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ингээд тасралтгүй явуулж байна. Шүүхийн тухай хуульд заасны дагуу Сахилгын хороо бүрэн эрхийнхээ хүрээнд шүүгчийн сахилгын зөрчилтэй холбогдуулан хүн, албан тушаал, хуулийн этгээдээс 21 өргөдөл гомдлыг тайлан тоонд хүлээж авч хянан шийдвэрлэсэн байгаа. Үүнээс 139 өргөдөлд хэрэг үүсгээд 180 өргөдөлд хэрэг үүсгэхээс татгалзсан ийм баримттай ажиллалаа.

Сахилгын хорооны зөвлөгөөнийг 26 удаа зохион байгуулж, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хорооны дарга, гишүүний 1398 захирамж, 116 тогтоол, 137 магадлал, сахилгын зөрчил гаргасныг нотлох 33 дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох 132 санал, хяналтын тогтоол зэрэг эрх зүйн актуудыг гаргасан гэдгийг эхлээд танилцуулъя.

Түүнчлэн 2024 оны 6 сарын 5-ны өдөр Монгол Улсын шүүхийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өргөдөл мэдээллийг цахимаар гаргах, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах зэрэг зохицуулалтууд тусгагдсан. Шүүхийн сахилгын хорооны өнгөрсөн хугацаанд хийж хэрэгжүүлсэн цахимжилтын бодлого, түүний хэрэгжилтийг эрчимжүүлэх, үе шаттайгаар нэмэгдүүлэх эрх зүйн үндсэн суурь болсон. Нөгөө талаараа бол цахимжуулалт эрчимжсэнээр төсөвт мөн тодорхой хэмжээний хэмнэлт гаргах ийм нөхцөл бүрдсэн гэж үзэж байгаа.

Шүүхийн сахилгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны төсвийн төслийг Төсвийн тухай хууль, Монгол Улсын шүүхийн тухай хуульд тус тус нийцүүлэн 6.8 тэрбум төгрөгөөр тооцоолж урсгал зардлын төсвийн төсвийг боловсруулсан. Үүнийг задалбал цалин хөлс болон нийгмийн даатгалын зардлыг 54 тэрбум төгрөгөөр, бараа, бусад үйлчилгээний зардлыг нэг аравны тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөсөн байгаа.

Харин энэ 2026 оны төсөвт Шүүхийн сахилгын хороо хөрөнгө оруулалтын төсөв тусгаагүй, урсгал зардлыг зүгээр цалин хөлс Нийгмийн даатгалын шимтгэл 5.4, байр ашигтай холбоотой зардал, мөн хангамж, бараа материалын зардал 319 сая, норматив зардал 20 орчим сая, эд хогшил, урсгал засварын зардалд 250 орчим сая, томилолтын зардалд 120 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжид 248.6 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 125 сая

төгрөг, бусад урсгал шилжүүлэгт 258.9 сая төгрөг гээд нийтдээ төсвийн төслөө 6 тэрбум 848 сая төгрөгөөр бид бид ингэж санал оруулж ирж байгаа. Баярлалаа.

О.Номинчимэг: Танилцуулга хийсэн Ариунтуяа даргад баярлалаа.

Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс Шүүхийн сахилгын хорооны 2026 оны төсвийн төсөлд хийсэн дүн шинжилгээний талаарх танилцуулгыг та бүхэнд бас мөн хүргүүлсэн байгаа.

Ингэхээр Шүүхийн сахилгын хорооны 2026 оны төсвийн төслийн урсгал зардал болон хөрөнгө оруулалтын зардалтай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Хамтад нь асуулт үг хамтдаа явъя Ганбат гишүүнээр тасаллаа Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Миний асуулт аягүй товчхон. Би тэгэхдээ буруу ойлгож байж магадгүй. Та хэд маань залруулаарай. Бид нарт ирсэн материалаар энэ орон тооны мэдээлэл дотор гүйцэтгэх ажилтан 23, удирдах ажилтан 13 гээд байгаа байхгүй юу. Үйлчилгээний ажилтан 19 гээд. Нөгөө 23 хүнд 13 дарга л гэж би ойлгох гээд байх юм. Тэгээд энэн дээр бүтэц орон тооны хувьд эсвэл яаж явдаг юм? Энэ дээр нэг зөв мэдээлэл өгөөч.

О.Номинчимэг: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон Ариунтуяа дарга хариулъя.

Д.Ариунтуяа: Энэ 13 дарга гэдэг маань 9 гишүүн маань орчихсон байгаа. Тэгээд манайх ерөнхийдөө бүтцээрээ 3 хэлтэстэй. Тэгээд ажлын албаны дарга гэсэн 4, ажлын алба бол 4 даргатай. Тэгээд 9 гишүүнээ оруулаад 13 удирдах албан тушаалтан гэдэг байдлаар оруулсан. Нэмж тайлбар хэлэхэд орон тооны хувьд Сахилгын хороо ер нь орон тоо их бага ажиллаж байгаа. Ер нь бол өөрийнхөө бүрэн эрхийн хэмжээнд бид нар 64 орон тоо гэсэн орон тоотойгоор батлагдаж ажилласан. Энэ бусад гишүүд нь ороод. Тэгээд хэмнэлтийн хуулийн дагуу өнөөдөр бидэнд төсвийн хэмжээ нь 55 орон тоотойгоор өөрөөр хэлэх юм бол 9 гишүүнээ хасах юм бол бид 40 орчим орон тоотойгоор ажлын алба ажиллаж байгаа.

Тэгэхээр одоогийн төсөв дээрээ бид батлагдсан орон тооныхоо хэмжээгээр 64 орон тоотой ажиллах гэдэг төслөөр орж ирж байгаа.

Тэгэхдээ энд бол бас 9 гишүүн маань орчихсон байгаа.

О.Номинчимэг: Ойлгомжтой. Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууж үг хэлье.

Д.Ганбат: Шүүхийн сахилгын хороо Үндсэн хуулийн байгууллага болоод 3, 4 жил болж байна уу? 4, 5 жил ч билүү. Яах вэ бид нар чинь 5 жил тутам хууль дээр бас нэг үнэлэлт, шинжилгээ ийм юм хийх ёстой л доо. Сахилгын ерөнхий хороо, Шүүхийн сахилгын хороо маань хэр ажиллаад байна аа? Орон тоо бол 64 их л юм байна шүү дээ. Энэ бол захиргааны байгууллага. Шүүх биш ээ. Тэгэхээр эндээс бид нар тэр хууль номоор нь хэмнэлт хийж болох ёстой гэж бодоод байна. Хэдий

хэмжээний энэ 9 хувь орон тоо хасах ёстой гэж байгаа. Бас 11 хувийн төсвийн тодотголоор хэмнээ гэж байгаа тэр үйлчилж байгаа юу? Хэ хэдий хэмжээний ийм хасаж байж гарч байгаа юм энэ онд гэсэн ийм асуулт байна.

Нөгөө талаар бол энэ Сахилгын хороо чинь 9 хүнтэй, 9 гишүүнтэй байхаа. 5-ыг нь албан тушаалтнууд буюу эндээс сонгоод явуулж байгаа. 4 нь шүүгч гишүүн байгаа байх. Сахилгын хорооны дарга нар яаж сонгогдоод байна. Шүүгч гишүүн ер нь сонгогдсон удаа байна уу байхгүй юу? Тэгээд танайхаас чинь энэ шүүхийг хараат бус байх шүүгчийг хэр хэмжээнд яаж ажиллах ёстой юм тэ? Санал гомдлыг хүлээж аваад шийддэг ийм л байгууллага л даа. Гэхдээ нэг ийм юм байна. Монгол Улс шүүхийг шүүхийн үйл ажиллагаа шүүх ганцхан шүүх хэрэгжүүлнэ гэж байгаа шүү дээ Үндсэн хуульд тийм ээ.

Тэгэхэд танайхаас гарсан шийдвэрээр хэдэн шүүгч ажлаасаа халагдаад байна гэсэн ийм нэг асуулт байна. Танай гаргаж байгаа шийдвэрийг та нар чинь гэм бурууг нь тогтоогоод тэгээд яг шүүх шиг ялладаг юм уу. Хэн нэгэн давах ч юм уу, хянах ч юм уу тийм шатанд хандах бололцоо бий юу? Тэгэхээр наад та нарын хийж байгаа ажил чинь нэг л тийм хууль номд нийцэхгүй болчих гээд байна уу үгүй юу? Үндсэн хуульд. Тэрийг яах ёстой юм. Нөгөө талаараа Шүүхийн сахилгын хороог зарим талдаа бүүр эсрэгээрээ шүүгч нарыг аль болохоор хараат ажиллуулах тийм хороо болчих гэсэн ийм талтай байна уу, үгүй юу гэж харагдаад байна аа.

Энийг буруугаар ашигладаг зөв тийш нь явуулдаггүй ийм нөхцөл байдал үүсгээд байна гэсэн санал гомдлууд надад их ирж байна аа. Энийг би тодруулъя.

О.Номинчимэг: Ганбат гишүүний асуултад ажлын хэсгийн 4 дүгээр микрофон Ариунтуяа дарга хариулъя.

Д.Ариунтуяа: Орон тооны хувьд бол Ганбат гишүүний асуултад хариулъя. Орон тооны хувьд бол бас жоохон ташаа ойлголт авчих шиг боллоо.

Яг одоогоор манай ажлын алба 44 орон тоотойгоор ажиллаж байгаа гэдгийг хэлье. Төсвийн 2026 оны төсвийн төсөлд бид өнгөрсөн онд Улсын Их Хурлаас цалин нэмэгдсэнтэй холбогдуулаад цалингийн төсөв өсөлттэй орж ирж байгаа. Ерөнхийдөө манай төсвийн 80 гаруй хувь нь цалинтай холбоотой орж ирдэг. Харин нэлээн хэдэн асуудал дээр бас бид нар байрны түрээсийн 97 сая төгрөгийг бид нар хасалттай оруулж ирсэн. Энэ сая хэлж байсан цахимжилттай холбоотойгоор шуудан холбооны зардлыг бас мөн бага хэмжээгээр хасалттай оруулж ирж байгаа. Багаж техник хэрэгсэл дээр мөн хасалттай оруулж ирж байгаа. Бас нийтлэг ажил үйлчилгээ буюу даатгалын үйлчилгээн дээр мөн хасалттай гэсэн төслүүдийг бид саналдаа оруулж ирсэн ийм байдалтайгаар байгаа.

Дараагийн асуулт нь Шүүхийн сахилгын хороо нь өнгөрсөн хугацаанд 3 жил гаран ажиллаж байна. Энэ хугацаанд бол нийт тоогоороо 1400, 500 орчим өргөдөл мэдээллийг хүлээж авч шийдвэрлэсэн байгаа. Тэгэхээр маш товчхон тодорхой хэлэх юм бол өнөөдрийн байдлаар яг хүчин төгөлдөр болсон шийтгэл ноогдуулсан 49 шүүгчид шийтгэл ноогдуулсан байна. Үүнээс хаалттай сануулах 13, нээлттэй сануулах 22, цалингийн хувиар бууруулах 13, шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлээд суулгыг даатгах нэг, огцруулсан 4 шүүгч гэсэн ийм шийтгэлүүд оногдуулсан ийм мэдээ баримт байгаа. Цаашаа давдаггүй гэж байна.

Шүүхийн сахилгын хороо Сахилгын хорооны хуралдаанаараа 2 шүүгч гишүүн, шүүгч бус гишүүн нэг шүүгч гишүүнтэйгээр хурлаа хийдэг.

Ингээд магадлал гарна. Хуралд сахилгын хэргийн оролцогч буюу шүүгч гомдол гаргах эрхтэй. Энэ гомдлыг Шүүхийн сахилгын хороонд өөрт нь гаргадаг. Гомдлын хуралдаанд бол шүүгч 2 гишүүн, шүүгч бус нэг гишүүн хянан үзэх хуралдаанаар хэлэлцээд шийдвэрээ гаргадаг. Энэ тогтоолд мөн гомдол гаргах эрхтэй. Энэ Улсын дээд шүүхэд 2 үндэслэлээр гомдол гаргаж байгаа.

Нэгдүгээрт эрхээр хангаагүй.

Хоёрдугаарт тов мэдэгдэж хуралдаанд оруулаагүй гэсэн 2 үндэслэлээр Улсын дээд шүүхэд мөн гомдол гаргах энэ эрх нь нээлттэй байгаа. Сахилгын хорооны даргын хувьд Шүүхийн тухай хуульд заачихсан байгаа. Зөвлөгөөнөөр шийдвэрлэдэг. Зөвлөгөөн нийт гишүүдийн нууцаар санал хураалтаар нийт гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэдэг. Яг энэ журмаараа бид шийдвэрлээд явж байгаа.

О.Номинчимэг: Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Шүүхийн сахилгын хороо байгуулагдаад ажиллаад албан ёсоор 3 жил болж байгаа юм байна гэж ойлголоо. Тэгээд энэ шүүхийн хараат бус байдал энэ 3 жилд яаж сайжирсан бэ? Сайжирсан уу? Муудсан уу? Эсрэгээрээ муудаад л байх шиг байх юм. Тэгэхээр та нарын ажил чинь зөв тийшээ яваад байна уу, буруу тийшээ яваад байна уу? Өөрсдөө юу гэж үнэлдэг юм.

О.Номинчимэг: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон, Ариунтуяа дарга.

Д.Ганбат: Ганбат гишүүний асуултаар шүүх шүүхийн хараат бус, бие даасан бие даасан байдлыг хангах чиг үүрэг бол ШЕЗ хэрэгжүүлдэг. Шүүх шүүхийн сахилгын хороо бол шүүгчийн сахилга хариуцлагатай холбоотой шүүхэд заасан үндэс шүү. Шүүхийн тухай хуульд заасан үндэслэлээр огцруулах хүрэх арга хэмжээ авах хүртэлх энэ чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тэгэхээр хараат бус байдал болон бие даасан байдалтай холбоотой асуудал нь өөрөө ШЕЗ-ийн эрх хэмжээ.

Зүгээр Шүүхийн сахилгын хороо өөрийнхөө бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ шүүгчийн бие даасан шүүхийн хараат бус байдалд хүндэтгэлтэй ханддаг л гэж хэлмээр байна даа.

О.Номинчимэг: Энэ шүүхийн ШЕЗ дээр ч гэсэн 2 жил тутамдаа энэ нөгөө Нээлттэй нийгмийн хүрээлэнгээс шүүхийн хараат бус байдалтай холбоотой. Тэр үзүүлэлтүүдээ хэлчхээч?

Танайтай холбоотой үзүүлэлт чинь сайжирчихсан байгаа шүү дээ.

Д.Ариунтуяа: Тэгсэн. Яг 2 жил тутам шүүхийн индекс гарч байгаа. Тэгэхээр 2 жилийн өмнөхөөс нээлттэй ил тод байдалд ажиллаж байгаа шүүхийн сахилга хариуцлага сайжирсан гэдгээр огцом нэмэгдсэн энэ нь бол хорин хэдэн хувиас 80 хувь хүртэл хэмжигдсэн нь Шүүхийн сахилгын хороо байгуулагдсантай холбоотой гэж үзэж байгаа.

Тэгэхээр сахилга мэдээж ёс зүйтэй, хариуцлагатай шүүх төлөвлөснөөр шүүх дэх олон нийтийн итгэл нэмэгдэнэ. Тэгэхээр энэ хүрээнд Сахилгын хороо өөрийнхөө чиг үүргийг хуульд заасны дагуу хэрэгжүүлээд явж байгаа. Тэгэхээр хөндлөнгийн судалгаагаар энэ дээр нэлээн өсөлттэй гардаг гэдгийг нь хэлмээр байна аа.

О.Номинчимэг: Яах вэ энд нөгөө тодруулж хэлэхгүй бол та хэд бас тоогоо харж хэлэхгүй бол шүүхийн 2021 онд хийгээд сүүлд 2023 онд хийсэн юм байна. Тэгээд шүүгчийн ёс зүй ба хариуцлагын асуудал бол 2021 онд 45.17 хувьтай. Тийм үнэлгээтэй байсан бол 2023 оны судалгаагаар 58.13 гээд өссөн үзүүлэлттэй. Яг ёс зүй хариуцлагатай холбоотой индекс нь өсөлттэй тийм бууралттай асуудлууд ч гэсэн байгаа.

Ингээд төсвийн төслийн урсгал зардал буюу хөрөнгө оруулалтын зардалтай холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтдаа бэлдье.

Шүүхийн сахилгын хорооны 2026 оны төсвийн саналыг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сан сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг тусгасан хувилбарыг улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр хянасныг Шүүхийн сахилгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

66.7 хувиар санал дэмжигдлээ. Ажлын хэсэгт баярлалаа.

11.41 цаг

Дараагийн асуудалд оръё.

Төсвийн талаарх 4 дүгээр асуудал болох ХЭҮК-ын 2026 оны төсвийн төслийг хэлэлцье ээ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцох албан тушаалтнуудыг танхимд оруулъя.

ХЭҮК-ын дарга Сүнжид, ХЭҮК-ын Тамгын газрын дарга Адьяахишиг, ХЭҮК-ын Санхүү хөрөнгө оруулалтын тасгийн дарга, Ерөнхий нягтлан бодогч Бадамсэрээжид нар оролцож байна.

ХЭҮК-ын 2026 оны төсвийн төс төслийн талаарх танилцуулгыг ХЭҮК-ын дарга Дугарын Сүнжид танилцуулна.

Бидэнд Тамгын газраас хяналт шалгалт хийсэн нэлээн нарийвчилсан танилцуулга аль хэдийн тараагдсан байгаа учраас та танилцуулгаа 3 минутад багтаан хийж өгнө үү гэж хүсье.

Д.Сүнжид: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 6.1 дэх хэсэгт Монгол Улсын ХЭҮК-ын дарга жилийн төсвийн төслийг төлөвлөн Улсын Их хуралд хүргүүлэх бөгөөд төслийг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлнэ гэж заасан. Мөн хуулийн 31.3 дахь хэсэгт эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааны төсвийн чиг үүргээ бүрэн тасралтгүй, үр нөлөөтэй, хараат бусаар эрхлэн явуулахад хүрэлцэхүйц байна аа.

Хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааны урсгал зардлыг комиссын төсөвт тусгах бөгөөд хорооны гишүүнд урамшуулал олгох журмыг комисс батална гэж тус тус заасныг үндэслэн Монгол Улсын ХЭҮК-ын 2026 оны төсвийн төслийг НҮБ-ын Ерөнхий ассамблейгаас 1993 онд баталсан хүний эрхийн үндэсний байгууллагуудын талаарх Парисын зарчим, комиссын төсөв, үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байх зарчимд нийцүүлэн боловсруулж 2020, 2025 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 01/1055 дугаартай албан бичгээр Улсын Их Хурлын даргад хүргүүлсэн билээ.

ХЭҮК-ын төсвийн төсөл нь алсын хараа 2050 хөгжлийн зорилтот хөтөлбөрийн зорилтууд, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтуудад тус тус уялдаж байгаа. Мөн түүнчлэн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн үзүүлэлт, Худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөөний төсөл, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан боловсруулсан болно.

Комисс нь Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан чиг үүрэг хэрэгжүүлдэг. Үүнээс гадна Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу хяналт шалгалт, сургалт, мэдээлэл, тайлан хүргүүлэх, олон улсын гэрээнд байр суурь илэрхийлэх мэдээлэл хүргүүлэх гэсэн энэ чиг үүргийг хэрэгжүүлж байна аа.

Монгол Улсын ХЭҮК-ын байр болон Ази, Номхон далайн бүс нутгийн хүний эрхийн төвийн барилгыг шинээр барих төсвийг холбогдох хууль журмын дагуу төлөвлөж, 2026 оны хөрөнгийн зардлын төсөвт хөрөнгийн зардал болох 25.1-д 1 тэрбум төгрөг, урсгал зардал 13.4 тэрбум төгрөг, нийтдээ 38.5 тэрбум төгрөг байхаар тооцож төсвийн төслийн саналыг хүргүүлж байна.

2026 оны төсвийн төсөл нь 2025 онд батлагдсан төсвөөс хөрөнгийн зардлын хувьд 22.4 тэрбум төгрөгөөр урсгал зардлын хувьд 1.4 тэрбумаар нэмэгдсэн. Урсгал зардлын нэмэгдлийн 76.8 хувь нь цалингийн сангийн нэмэгдэл эзэлж байна аа.

Орон тоог өмнөхөөс нэмэгдүүлээгүйд тооцлоо.

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д комисс үйл ажиллагаа явуулах байртай байна гэж заасан. Монгол Улсын Их Хурлын 2023 оны

114 дүгээр тогтоолын 2 дахь хэсэгт хүний эрхийн мэдлэг олгох, сургах, чадавхжуулах чиглэлээр НҮБ-ын харьяа Ази Номхон далайн бүсийн төвийг Монгол Улсад байгуулах санаачилга гаргаж шийдвэрлэх талаар идэвхтэй ажиллахаар заасан. Мөн энэ Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.10, 12-т туссан.

О.Номинчимэг: Сүнжид даргад баярлалаа.

ХЭҮК-ын 2026 оны төсвийн төслийн урсгал зардал болон хөрөнгө оруулалтын зардалтай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Одонтуяа гишүүнээр тасаллаа.

Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Төсвийн төслийг зарчмын хувьд дэмжиж байна. Ингээд хүргүүлэх нь зөв байх. Яах вэ энэ ХЭҮК-ын хуулийг би өөрөө бас яг гардаж бичсэн хүн л дээ. Анх удаа энэ хуулийг бичиж хүн өөрийгөө төрийн өндөр албан тушаалд дэвшүүлэх тэр боломжийг бүрдүүлсэн.

Үүний дараагаар Шүүхийн сахилгын хороо, ШЕЗ ч гэсэн энэ зарчим ингээд үйлчлээд явсан. Энэ хууль дээр бас нэг зүйл юу вэ гэхээр Монгол Улсын хамтын НҮБ-ын өмнө хүлээсэн бас гэрээ конвенцоор хүлээсэн үүрэг болох энэ эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизмын асуудлыг оруулж ирсэн юм. Энэ урьдчилан сэргийлэх механизмын чиг үүрэг маань сүүлдээ Комиссын хуулийг бичиж байсан. Үзэл санаанаасаа задарч давхиад Хүний эрхийн хамгаалагчийг хууль хийхдээ бүрэн аваачиж жоохон буруу ойлголтыг төрүүлээд бие даасан барилга байгууламжтай болно гээд энэ комиссын байранд байдаггүй тусдаа гараад суучихсан. Тусдаа баахан хүмүүс найз нөхдүүд хоорондоо цуглараад суучихсан ийм зүйл рүү орлоо. Сүүлдээ нөгөөдүүл маань урьдчилан сэргийлэх функцтэй гэдгээ ойлгохгүй, гомдол мэдээллээ хянан шалгадаг комиссын хяналтууд төрийн байгууллага дээр давхардаж очоод дандаа хүндрэл учруулж байна шүү дээ. Тэгээд та нарын өөдөөс юм ярьж чадахгүй юм бас. Та хэд нэг яваад очно.

Жишээ нь ШШГБ дээр. Дараа нь тэр эрүүдэн шүүлтийн нөхөр чинь дахиад нэг юм очно. Тэгээд бид хэд ингээд хүний эрх яриад ингээд бас явж байгаа мөртөө ингэж энийг буруугаар ашиглаж энэ бичиж өгсөн хуулийг ингэж бүр жонхууруулдаг бас ийм хүний хүчин зүйлүүд их байна аа. Тэгээд энэ зүйлүүдийг бас нэг эргэж харах комиссын гишүүн бол 5 байхад л хангалттай байгаа юм. Тэгээд сая бас хүний эрхийн хамгаалагч хуулиар энэ тэрээ нэмэгдүүлж барьж өгөөд ингээд сүүлдээ хэд ч яваад байгаа юм бүү мэд. Тэгээд сүүлдээ тусдаа байр майр гээд одоо ерөөсөө энэ завхралыг бас ер нь би Байнгын хорооны гишүүддээ хэлж байгаа юм. Засах хэрэгтэй байх аа. Тэгэхгүй ингээд удирдлагууд ч юм уу, Байнгын хорооны удирдлагууд нэг буруу ташаа мэдээлэл өгдөг. Сүүлдээ ингээд урьдчилан сэргийлэх функцээсээ халиад гомдол мэдээлэл янз янзын юм руу хутгалдаж ордог энэ байдал чинь хэрвээ хүний эрхийг хамгаалах биш хүний эрхийг бүр дордуулна ийм зүйлүүд байна.

Тэгээд би энийг бас зарчмын хувьд гишүүд бас цаашдаа анхаарах ёстой шүү. Комисс ингээд бас комиссарууд буюу энэ хүний эрхийн комиссын гишүүд маань бас яг тодорхой сэдвийн хүрээнд үйл ажиллагаа явуулчих бололцоотой. Гэтэл ингээд бас бие даасан байдалтай сүүлдээ энэ хуулиа бараг салгаж тусдаа байгууллага

болох энэ тэр ярьж байна гэсэн. Энэ хувилбар нь бол ХЗДХ-ийн юман дээр ч байж болно. Тэр урьдчилан сэргийлэх механизм. Тэнд дүн шинжилгээ хийгээд яг энэ эрүү шүүлтийг гаргахгүй байх дүн шинжилгээ хийгээд байж байгаа болохоос биш баахан юу гэдэг юм эрх мэдэл авангуутаа гомдол шийдээд ингээд комисстойгоо зэрэгцээд энэ ерөөсөө ингээд бас болохгүй болчихсон байгаа шүү. Тэгээд би энийг бас энэ Хууль зүйн байнгын хорооны протоколд үлдээх ер нь зүгээр цааш цаашдаа бас анхаарах ёстой. Хэмнэж байгаа бол би хүний эрхийг хамгаалъя хамгаалахгүй гэж байгаа юм биш. Тэгэхдээ энэ комиссын гишүүдийн тоо бол...

О.Номинчимэг: Сайнзориг гишүүн үг хэллээ. Салдангийн Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Оруулж ирж байгаа төсвийг бол яах вэ би дэмжээд явна. Сая 1 зүйлтэй холбоотой бас нэг асуулт асууя. Бас Сайнзориг гишүүн ч хэллээ. Ер нь зүгээр бид нар энэ эрүүдэн шүүхийн асуудалтай холбоотой зүйлийг бас манай Улсын Их Хурлын гишүүд бид нар бас өөрсдөө дотроо нэг ийм нэгдсэн зөв ойлголттой болох ёстой юм байна лээ. Би анх бас л яг Сайнзориг гишүүн шиг бодолтой байсан. Гэтэл олон улсын Эрүүдэн шүүхийн НҮБ-ын тэр байгууллагын комиссарууд ирээд бид нар уулзалт хийгээд би өнгөрсөн 4 жил тэд нартай бас ажиллахад эрүүдэн шүүхийн энэ асуудал зайлшгүй тусдаа ер нь бие даасан байх ёстой гэдэг ийм л байр суурь барьдаг юм байна лээ. Яг одоо тэр байгууллагынх нь хэлбэр бол хамаагүй. Хаана ямар дотроо байх нь. Яасан гэхээр тэр комиссарууд ирээд нэг хорих анги дээр очиход шууд хэлэхгүйгээр шууд очоод бодит байдалтай танилцах гэтэл аль уже мэдчихсэн бүр бүх юм нь бэлдчихсэн бараг гадаа нь хүмүүс ингээд ёслоод зогсож байх жишээтэй. Тэр бол энэ олон улсын гэрээ конвенцын дагуу асар их том зөрчил байхгүй юу. Ерөөсөө энийг хэн ч мэдэхгүй байх ёстой. Гэтэл манайд яагаад байна вэ гэхээр би өнгөрсөн 4 жил бас энэ дээр ажиллаж байхад яах аргагүй төсөв нь томилгоо нь хараат байдаг учраас энэ асуудал чинь буруу байна гээд л. Энэ комиссарууд бас ийм зөвлөмж гаргадаг юм.

Тэгэхээр ер нь манай энэ Байнгын хороон дээр яг энэ талаар бид нар яг ийм нэгдсэн зөв ойлголттой болох ёстой юм билээ. Дээрээс нь би яг комиссын даргаас асуух гээд байна л даа. Одоо энэ та нар төсөв нь ингээд саланги байж чадаж байгаа юу. Өнгөрсөн хугацаанд нэг төсөв нь тусдаа байх ёстой гэхчихсэн байна. Нэг 0 байгаад байдаг. Тэр Хүний эрхийн комиссын даргаасаа л нөгөө төсвөө ороод л батлуулна, унаагаа авна. Ингэхээр чинь энэ чинь нөгөө хараат байж чаддаггүй юм байна л даа. Яагаад гэхээр манай Монгол Улсад гарсан эрүүдэн шүүлтийн том кэйсүүд дандаа ардаа маш том улс төрийн том артай ийм юмнууд явж байсан учраас энэ болохгүй байгаа.

Тэгээд дээрээс нь Их Хуралд энэ 2 чинь тусдаа тайлан гаргадаг байхгүй юу. ХЭҮК-ын тайлан тусдаа, эрүүдэн шүүхийн тайлан чинь тусдаа гардаг. Тэгэхээр энэ тусдаа гарч байгаа юм чинь тусдаа л байх ёстой байхгүй юу. Гэтэл энэний бүх төсвийг нь бүх юмыг нь комиссын дарга мэдээд явахаараа л яг олон улсын конвенцын тэр зөрчил үүсээд байгаа юмаа. Тэгэхээр ер нь бид нар бас энэ талаар ийм чухал ойлголттой болох ёстой юм байна лээ. Тэгэхээр ер нь урьдчилан сэргийлэх талаар би нэлээн их шат ахисан, сайн зүйлүүд хийсэн гэж үзэж байгаа. Яах вэ зүгээр зарим хүмүүс тэр тэнд ажиллаж байгаа хүмүүс юм уу тухайн нэг хүндээр нь жоохон асуудал бас ингээд яриад байдаг юм билээ. Би зүгээр зарчмын хувьд ярихад ерөөсөө эрүүдэн шүүхийн энэ урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа бол маш тусдаа байх ёстой, бүх юм нь тусдаа...

О.Номинчимэг: Одонтуяа гишүүний асуултад ажлын хэсгийн 3 номер Сүнжид дарга хариулъя.

Д.Сүнжид: Сайнзориг гишүүн, Одонтуяа гишүүний асуулт, саналд нь нийлүүлээд хариулъя. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа гэж Монгол Улсад 2021 оны Комиссын хуулийн шинэчилсэн найруулгаар батлагдсан. Энэ чиг үүрэг энэ механизмаас гадна хүний эрх хамгаалагчийн гэж тусдаа нэг механизм бий болсон хуулиар. 3 дахь нь Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулиар бас чиг үүрэг харьяалуулсан. Яг адилхан 3 дагнасан чиг үүргийг хэрэгжүүлж байгаа механизмыг ХЭҮК дотроо дагнасан комиссоор хариуцан ажиллах байдлаар ингэж зохион байгуулалттай явж байгаа. Төсвийн хувьд ангиллын зардлын ангиллын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь тусдаа байгаа. Өөрөөр хэлэх юм тусдаа кодтой явж байгаа.

Тэгээд энэ комиссын нийт төсвийн 10 хувийг эзэлж байгаа. Хүссэн төсөв болгоныг нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа авч байгаа. Нөгөө 2 механизмын хувьд бол тийм хэрэглээг эдлэхгүй байгаа. Өөрөөр хэлбэл ийм шаардлага адилхан олон улсын гэрээ конвенцоор үүрэг хүлээсэн, тодорхой дагнасан чиг үүрэг хэрэгжүүлдэг ийм мандаттай боловч яг ийм байдлаар төсвөө тусдаа зардлын ангиллаар гаргаагүй. 10 хувьдаа хүрэхгүй төсвийг энэ 2 мандат чиг үүрэгт зарцуулдаг юм. Тэгэхээр цаашдаа Хууль зүйн байнгын хорооны гишүүдээс Сайнзориг гишүүний бас хэлж байгаа тэр саналтай холбоотой. Бид хэд энэ хуулиар л энийг тодорхой болгох учиртай.

Одоо бол комиссын дэргэд байгаа учраас Комиссын удирдлага зохион байгуулалтаар явна. Хараат бус гэдгийг бид юу гэж ойлгодог вэ гэвэл тэр хүн шийдвэрээ хараат бусаар гаргана, хэн нэг улс төрийн бусад байгууллагын албан тушаалтны нөлөөгүйгээр үйл ажиллагаагаа явуулаад шийдвэрээ хараат бусаар гаргана. Тэгээд бид нар хүлээсэн үүрэг юу вэ гэхээр урьдчилан сэргийлэх, урьдчилан сэргийлэх гээд тодорхой газруудыг нэрлэн заачихсан. Тэгээд зарим тохиолдолд давхцаж байгаа үйл ажиллагаа. Би Сайнзориг гишүүний хэлж байгаа тийм ийм юу бол байгаа. Комисст өөр ер нь энэ мандат нь явж байгаа, гомдлыг бид хүлээж авч шалгадаг. Эрүүдэн шүүгдлээ, хэрцгий, хүнлэг бус харьцлаа, нэр төрд халдлаа гэдэг гомдлыг комисс манай гишүүд мандатынхаа хүрээнд шалгаж байгаа бол урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулж байгаа гишүүн нь урьдчилан сэргийлэх сургалт нөлөөллийн ажил хийх энэ талаар хэлэлцүүлэг зохион байгуулах ийм ажлыг хийдэг ээ.

Тэгэхээр харилцан уялдаатай ажиллах ёстой. Бие биеэ нөхөн гүйцээх ёстой атал зарим талаар бас ийм давхацсан чиг үүрэг гараад байгаа юм. Тэгэхээр бид нар яаж төрийн энэ албан хаагчдад тодорхой заасан институцтэй хялбар давхардалгүйгээр давхар очилгүйгээр энэ чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэх вэ гэдэг талаас нь бодож үзэх ёстой болоод байгаа юмаа. Тэгээд эндээ институцийн хооронд түвшинд ярилцах шийдэл хайхын сацуу хуульд бас нэмэлт, өөрчлөлт оруулах замаар бас шийдэх ийм боломжтой ийм байгаа төсвийн хувьд ингээд тусад нь ангилал гаргасан байна аа.

О.Номинчимэг: Яг энэ асуудалтай холбоотойгоор Улсын Их Хурал дээр бас ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байгаа. Энэ эрүүдэн шүүлттэй холбоотой, гэрч хохирогчийг хамгаалахтай холбоотой гээд Тэмүүжин гишүүнээр ахлуулсан яг энэ хүний эрхийн комисс Эрүүдэн шүүлтийн асуудал хариуцсан урьдчилан сэргийлэх

конвенцын хэрэгжилтийн хүрээнд гишүүн ажиллаж байгаа тиймээ. Энэ маань яг үр дүн өгч байна уу гээд бид нар ч гэсэн бас ажлын хэсэг дээрээ дуудаж, нэлээн нарийн мэдээлэл эд нар авсан. Тэгээд яг практик дээр яг бас энэ гишүүдийн хэлж байгаа чиг үүрэг нь давхардсан. Нэг нь очоод л нөгөөх нь дагаж очоод л уг нь бол нэг нь гарсны хойно тиймээ нэг нь урьдчилан сэргийлэх байдал гарчихсан кэйс дээр хоёулаа очиж ингэж давхардаж ажилладаг тийм байдал ажиглагдаж байгаа юм байна лээ. Тэгэхээр энийгээ яг зөв чиг зөв болгох асуудал дээр яалт ч үгүй анхаарах ёстой.

Хоёрдугаарт яах вэ энэ нөгөө хүний эрхийн комиссын бас нэг чиг үүрэг чинь Улсын Их Хурал хүний эрхийн асуудлаар хянан шалгах чиг үүргээ хэрэгжүүлэх том өөрийнх нь механизм шүү дээ тиймээ. Одоо Аудит юу гэдэг юм энэ хүний эрхийн комисс гэдэг бол. Тэгтэл яах вэ зарим хүний хандлагын хувьд бид нар Улсын Их Хурлаас ямар ч хараат биш олон улсын гэрээ конвенцоор томилогдсон учраас гэсэн нэг тийм хандлага гаргадаг юм байна лээ. Өөрөө бараг НҮБ-ын элч төлөөлөгч шиг тиймээ. Тийм юм байхгүй. Энэ бол Улсын Их Хурал өөрөө баталсан хууль тогтоомж нь хэрэгжиж байна уу, хүний эрх, эрх чөлөөгөө хамгаалж чадаж байна уу гэдэг чиг үүргээ гүйцэтгэхэд мэргэжлийн энэ туслалцааг үзүүлдэг бие даасан ийм үйл ажиллагаа явуулдаг л ийм уг нь бүтэц баймаар байгаа юм.

Тэгэхээр хүний эрхийн комисс дээр энэ эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх энэ конвенцын дагуу ажиллаж байгаа ажилчид гишүүд нь бас энэ ойлголтоо цэгцэлж авахгүй хоорондоо ийм нэг жоохон зөрчилтэй тэгээд үр дүн нь жоохон тиймхэндүү л харагдаад байгаа. Тэгэхээр ажлын хэсэг бас энэ дээр байгаа учраас санал, дүгнэлтээ гаргаад тэгээд шаардлагатай хууль тогтоомжийг өөрчлөх хэрэгцээ гарах юм бол тэр хууль тогтоомжийг өөрчлөх саналыг бас гаргаад явах байх гэж бодож байна тиймээ Тэмүүжин гишүүн ахалж байгаа.

Ингээд Хүний эрхийн комиссын 2026 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг төсөлтэй холбоотой хөрөнгө оруулалт зардлын хамт явчихсан. Цуг явчихсан. Үг хэлэх юм уу та. Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлэх юм.

Б.Энхбаяр: Баярлалаа. Энэ ХЭҮК-ын Эрүүдэн шүүхийн асуудал эрхэлсэн комиссоор бие даасан байдалтай холбоотой асуудал хөндөгдсөн гэж байгаа учраас ер нь нэгэнт ХЗБХ-н дээр хөндөгдөж байгаа учраас бас Хууль зүйн байнгын хорооны гишүүд ер нь эрхэлж байгаа асуудлын чиглэлээр бас нэлээн судалгаатай, дүгнэлттэй байвал их зүгээр. Орох орохгүй бас энэ нэг хил хязгаар байгаа юм. Тэгэхээр эрүүдэн шүүхийн асуудлыг бид нар тусдаа бие даасан комиссоор л ажиллана гэсэн болохоос бие даасан байгууллага байгуулна гэж ерөөсөө яриагүй шүү дээ. Одоо ерөөсөө би хүнээ томилно, би төсвөө захиран зарцуулна гээд нэг ийм салан тусгаарлах үйл ажиллагаа явуулдаг нэг хүнтэй болчихсон. Тэгээд Их Хурал дээр орж ирж сонин сонин юм ярина.

Өнгөрсөн оны сонгуулийн өмнө Зоригийн хэрэгтэй холбоотой тэр Амгаланбаатар гэж ял шийтгэгдэж байгаа хүний камерт ороод, тэр хүнээс өөрөө бичлэг хийгээд сонгуулийн өмнө цацсан шүү дээ хүний эрхийн тэр комиссар. Яахаараа сонгуулийн өмнө тийм улс төрийн асуудал дээр татагдан орж, ямар зорилготой, хэний захиалгаар ийм мэдээлэл түгээж байдаг юм. Тийм учраас энэ асуудал дээр би бол их болгоомжтой хандаж ярьж байх ёстой гэж бодож байгаа гишүүд маань их нухацтай. Нөгөө талаар энэ одоо Хүний эрхийн дэд хороо манай Байнгын хорооны. Яахаараа манай улсад суугаа гадаадын Элчин сайд консулуудыг

дуудах асуудал ярьж байдаг юм. Гадаад яам хариуцаж байгаа шүү дээ. Аль ч улсын Элчин сайдын яамдын дипломат шугамаар харьцдаг этгээд чинь Гадаад яам шүү дээ. Яахаараа гадаад улсад байгаа гадаадын хууль тогтоомж байгаа үйлчилж байгаа тийм байрыг үзэх тухай ярьж байдаг юм. Тийм шийдвэр гаргаж байдаг юм.

Тийм учраас 2 орны харилцаанд нөлөөлөхүйц, олон улсын гэрээ хэлцэл хэм хэмжээг давсан асуудлыг ярих шийдвэр гаргах дээр их нухацтай бодож байх ёстой шүү. Тэгээд манай Байнгын хороо нэг жилийн яг хугацаа болох гэж байна. Ирэх 7 хоногт завсарлах нь байна. Энэ хуралдаа суудаггүй зарим хүмүүсээ гаргамаар байна. Миний мэдэхийн би энэ Халтмаагийн Баттулга гишүүн чинь манай Байнгын хорооны гишүүн юм байна лээ шүү дээ. Би сая л мэдсэн нэг ч хараагүй би. Жилийн хугацаанд. Ер нь яахаараа Хууль зүйн байнгын хороонд тэр хүн орчихсон явж байдаг юм. Одоо энэ шалгагдаж байгаа гэх юм уу, нэг албан тушаалаасаа буусан хүмүүс нь Ерөнхийлөгч, Ерөнхий сайдаасаа эхлээд дандаа энэ гадагшаа зугтдаг боллоо сүүлийн үед. Энэ дээр Аюулгүйн зөвлөл эд нар дүгнэлт хиймээр санагдаад байх юм. Улсын маш нууц, онц чухал нууц мэдээлэлтэй харьцаж байсан, танилцаж байсан хүмүүс ингээд гадаадад амьдраад байдаг. Хэний мөнгөөр амьдраад байгаа юм, хэний санхүүжилтээр амьдраад байгаа юм, хэнтэй уулзаад байгаа юм. Энэ асуудал дээр хүртэл нухацтай хандахгүй бол Хууль зүйн байнгын хороонд энэ Баттулга юу хийж байгаа юм ер нь. Хуулиас айгаад одоо өөрийгөө хамгаалах гээд энд орж ирсэн юм уу, яасан юм. Би мэдэхгүй дээ, нэг ч хуралдаа суугаагүй.

Тийм учраас энэ АН нам чинь энэ суудаггүй хүмүүсээ бас татаж ав л даа Ганбат ах аа. Танай Баянхонгорынх гээ биз дээ энэ чинь. Танай бүлгээр яриад энэ хуралдаа суудаггүй хүмүүсээ авмаар байна шүү дээ энэ чинь.

О.Номинчимэг: Үг хэллээ. ХЭҮК-ын 2026 оны төсвийн төслийн урсгал зардал болон хөрөнгө оруулалтын зардалтай холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явна. Санал хураалтдаа бэлдье гишүүд. Томьёоллыг уншиж танилцуулъя.

ХЭҮК-ын 2026 оны төсвийн саналыг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг тусгасан хувилбарыг улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр хянасныг ХЭҮК-ын төсвийг Ерөнхийлөн захирагчид хүргүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. 73.3 хувиар дэмжигдлээ. Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

Дараагийн асуудалдаа оръё гишүүд ээ. Одоо гуравхан асуудал байгаа.

3 дугаар асуудал. [Монгол Улсын ҮХЦ-ийн 2025 оны 6 дугаар дүгнэлтийг хэлэлцье ээ.](#)

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 9.1.3, 9.1.4-т заасан үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн үнээс бууруулж бүртгэхгүй гэсэн нь

Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай ҮХЦ-ийн 2025 оны 6 дугаар дүгнэлтийг гишүүдэд тараасан байгаа.

Энэ асуудалд Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчөөр Хууль зүйн байнгын хорооны гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал оролцсон байгаа ҮХЦ-ийн дүгнэлттэй холбогдуулан итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуух асуулттай эсвэл үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Уянгахишиг гишүүнээр тасалъя. Ганбат гишүүн. Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Цэцийн шийдвэр гарсан юм байна аа. Тэгээд бас ойлгож байна. Яах вэ зүгээр нэг ийм л зүйл байгаа. Одоо практик дээр нөгөө үл хөдлөх хөрөнгөө зарчхаад тодорхой татвараас зайлсхийх зорилгоор 2 гэрээ байгуулдаг үзэгдэл рүүгээ буцаад л орох гэж байна. Яг жинхэнэ гэрээ байдаг. Дээрээс нь яах вэ нөгөө үл хөдлөх хөрөнгөө бүртгүүлж татвараа төлөхтэй холбоотойгоор дахиад нэг гэрээ өгдөг. Сүүлдээ ингээд жоохон асуудлууд гараад ирэхээр нөгөө 2 гэрээгээ бариад шүүхдэлцээд ирдэг ийм л зүйл рүүгээ ингээд орох юм билээ.

Тэгээд яах вэ зүгээр ер нь аль ч оронд мэдээж үл хөдлөх хөрөнгийн асуудлуудыг тухайн тэр суурин газар буюу хотынхоо хэсэг дээрээ байршил, орох тухайн барилга байгууламжийн баригдсан цаг хугацаа, орц гэдэг юм уу үйл ажиллагааны чиглэл зэргээсээ яагаад л үнэлгээтэй байдаг. Тэрнээс биш хувь хүмүүс бас нэг их ингээд л тодорхойлоод л явдаг зүйл байдаггүй л юм байна лээ уг нь. Тэгээд яах вэ зүгээр энэ ингээд хүний өмчлөх эрх ч гэдэг юм уу, би өнөөдөр 100 төгрөгийн юмаа 50 төгрөгөөр зарах миний асуудал шүү дээ гэж байгаа боловч хэзээ ч одоо үл хөдлөх хөрөнгийг тэгж хямдруулаад л зарна гэсэн юм байхгүй шүү дээ.

Энэнээс гаргаад өнөөдөр хотын төвийн хуучин энэ 40, 50 мянгатын байрууд чинь яг үл хөдлөх хөрөнгийн бүртгэл дээр бараг 2 сая төгрөгөөрөө бүртгэлтэй л байж байдаг юм байна лээ. Энэний цаана нөгөө бас магадгүй энэ бас нөгөө талдаа өмчлөгчийн эрхийг хамгаалах гэж байсан юм. Байшин барилга нь нураад уналаа гэхэд бол бид нар чинь нөгөө хохирлыг барагдуулах чиглэлдээ яг улсын бүртгэл дээр байгаа үнэлгээгээр нь тооцож бас даатгал нь яригддаг ч юм уу, эсвэл буруутай этгээдээс төлбөр авах асуудал яригддаг юм шүү дээ. Энэ утгаар нь уг нь энэ бас уг нь дэвшилтэт байсан. Тэгэхдээ үнэхээр бас яах вэ Цэцийн шийдвэрүүдийг гарсан юм байна. Тэгээд би яах вэ зүгээр дараа дараагийн энэ цаашдаа гарах үр дагавар дээр нь харин яаж зохицуулалт хийж болох вэ л гэж бодоод байгаа 2 гэрээ рүүгээ явчихдаг. Тэгээд сүүлдээ ингээд худалдагч худалдан авагч тал нь маргаад ирэхээрээ баахан шүүх цагдаа явдаг, хуурамч бичиг баримт, гэрээ байгуулсан гээд ингээд л бие биеийнхээ юунуудыг ийм л юм руу түлхдэг юм даа. Тэгээд яах вэ энэ үзэгдэл рүүгээ л буцаж байна.

Магадгүй зүгээр газар хөдлөлт ч байдаг юм уу янз бүрийн байдлаар үл хөдлөх хөрөнгөд гэмтэл осол гарлаа, нурлаа гэхэд үл хөдлөх хөрөнгө дээр байгаа үнэлгээгээрээ яриад явах юм иргэд маань өөрөө ч хохирч мэдэх ийм л зүйл байгаад байгаа юм. Энийг тэгээд 2 талтай байгаа учраас ер нь зүгээр цэцийн шийдвэрийг хүлээж авсан тохиолдолд бас энэний гарц гаргалгааг бас бодох ёстой юм болов уу л гэж зүгээр бодож байна. Баярлалаа.

О.Номинчимэг: Үг хэллээ. Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Цэцийн дүгнэлтийг дэмжиж байгаа. Яагаад гэхээр яг энэ зүйл заалт хуульд нэмэлт өөрчлөлт орсноос хойш нэлээн яригдсан. Яагаад гэхээр Сайнаа Сайнзориг гишүүний хэлж байгаачлан 2 хэлцэл байгуулах ч гэдэг юм уу тиймээ, татвараас зайлсхийх байдлаар өөр хямд үнээр гэрээлдэг ч гэдэг юм уу асуудал байдаг. Гэхдээ энэ бол Иргэний хуулиараа зохицуулагддаг асуудал буюу хэрвээ хуурамч хэлцэл хийсэн бол энэ өөрөө хүчин төгөлдөр болдог. Нөгөө талаасаа үүнээс улбаалаад татвараас зайлсхийх гэдэг гэмт хэргийн одоо гэмт хэрэг болдог ч гэдэг юм уу тиймээ энэ асуудал бусад хуулиараа зохицуулагдаад явна. Ийм учраас яг хувийн эрх зүйн харилцаа буюу иргэд хооронд, хуулийн этгээд хооронд хийгдэж байгаа гэрээ хэлцлийн дүнг хязгаарлах зохицуулалт болоод ороод ирж байгаа учраас. Өөрөөр хэлэх юм гэрээгээ одоо ямар ч нөхцөл байдал үүсэж болно. Жишээлбэл юу гэдэг юм нэг 50 саяар бүртгэлтэй эд хөрөнгийг 40 саяар худалдах тийм үйл явдал угаасаа амьдрал дээр зөндөө тохиолдоно. Гэтэл тэрийг улсын бүртгэл дээр очихоор 40 саяар чинь бүртгэхгүй ээ, 50-иасаа заавал илүү үнээр бүртгэнэ гэдэг ийм асуудал тавигдаж орж ирж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ нь түрүүний ярьж байгаа Сайнзориг гишүүний ярьж байгаа тохиолдол эсвэл Баасанжаргал итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тайлбар дээр дурдагдсан байсанчлан төрийн харилцаа орж ирж байгаа тохиолдолд тэрийг тухай бүр нь одоо зохицуулж байгаа хуулиудаараа тухайлан зохицуулаад явахад болохгүй зүйл байхгүй ээ. Тийм учраас ҮХЦ-ээс энэ эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9.9.3 дахь хэсэг нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь заалтын үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах өмчлөх эрхтэй гэснийг тус тус зөрчсөн байна гэж үзсэнийг үндэслэлтэй гэж үзэж байна. Тийм учраас ҮХЦ-ийн 2025 оны 6 дугаар дүгнэлтийг дэмжиж байна.

О.Номинчимэг: Дэмжиж үг хэллээ. Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээж авах нь зүйтэй гэж үзэж байна аа. Тэртээ тэргүй бид нар чинь зах зээлийн нийгэмд ороод зах зээл л тогтооно шүү дээ. Өчигдөрхөн л одоо мянган төгрөг байсан талх 2 мянга болдог ч юм уу тиймээ энэ чинь бас буухгүй гэсэн үг шүү дээ. Буцаад л буух ёстой шүү дээ. Мянга болох ёстой гэх мэтчилний ийм л байх ёстой л доо. Тэгээд энэ үл хөдлөх хөрөнгө дээр бас хараад байхад их олон юм байна. Тухайлбал одоо төр энэ бүх юмаа иргэнийхээ өмнө хариуцна гэж байгаа юм. Хууль дээр тэгж байгаа. Гэтэл манай юу билээ бүртгэлийн байгууллага гэж байгууллага байгаа шүү дээ тиймээ. Иргэний бүртгэл мэдээллийн байгууллага гээд байгууллага байгаа. Дарга нар нь ч тогтдоггүй баахан авлига яригдаж байдаг ийм юм билээ. Энийг бид нар бас нэг мөр цэгцэлмээр байгаа юм. Тэр байтугай ХЗБХ-ноос ажлын хэсэг байгуулж, Иргэний бүртгэл мэдээллийн газарт шалгалт оруулах ёстой гэж би бодож байна. Яагаад вэ гэхээр хэд хэдэн удаа надад өргөдөл гомдол ирсэн. Тэрэн дээр бол одоо ямар нэгэн байдлаар энэ хууль хяналтын байгууллагууд бие биеэ ингээд байршуулчихаад, тэгээд үл хөдлөх хөрөнгийн бүртгэл хийдэг бүртгэгч нь яллагдагчаар татагдсан мөртөө захиргааны хэргийн шүүхэд хариуцагчаар ороод явж байдаг. Нөгөө гэрчилгээг нь дураараа бичиж өгдөг, хуулийн нөгөө бүрдэл хангаагүй байхад хэн дуртай хүнд үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ бичиж өгдөг ийм хүн нь одоо хүртэл ажиллаж байдаг. Ямар нэгэн арга хэмжээ авдаггүй ийм байдал бий болчихсон болохоор энэ хамгийн гол юм чинь бүртгэл мэдээлэл энэ баталгаа шүү дээ. Энийг төр хангах ёстой. Тэр ажил нь хийдэггүй, хийсэн ч одоо тийм хяналт доор байдаггүй ийм дураараа болсон нөхцөл байдал бий болсон юм билээ.

Энэ нь ч иргэд аягүй гомдолтой, энэ эрх их зөв үйлчилгээг нь хангаж өгөхгүй үйлчилж байна гэсэн ийм саналтай байдаг юм байна лээ шүү. Тэгэхээр энэ дээр бид нар нэг шалгалт оруулж ярилцах цаг болсон гэдэг юмыг хэлье ээ.

О.Номинчимэг: Дэмжиж хүлээж авах нь зүйтэй гэж дэмжиж үг хэллээ. Би ч гэсэн бас энэ асуудал дээр ер нь яах вэ Цэцийн дүгнэлтийг энэ удаа хүлээж авах нь зүйтэй гэж үзэж байгаа. Бид нар энэ хуулийн яах вэ зорилт нь түрүүний хэлж байсан тиймээ, ингээд нөгөө татвараас үл хөдлөхийн татвараасаа зайлсхийдэг ч байдаг юм уу, хэт бага үнээр бүртгүүлээд татвараас зайлсхийх үзэгдлийг л багасгая гэсэн уг нь зорилго байсан. Гэхдээ шийдэл нь жоохон болхи тиймээ болчих шиг болсон.

Ер нь ингээд харахаар бид нар нөгөө хөдөлмөр хийгээд л байгаа, ажил хөдөлмөр хийдэг хүмүүсээсээ маш их татвар авдаг. Тэгтэл энэ үл хөдлөх байдаг юм уу, газар байдаг юм уу ийм томоохон объектуудыг өмчилж байгаа хүмүүсээс ерөөсөө олигтой татвар бас авч чадахгүй байна. Тэр нь энэ үл хөдлөхийн бүртгэлийн үнэтэй холбоотой. Далд эдийн засагтай маш их холбоотой байгаа. Нөгөө нийгмийн шударга ёс гэдэг юмыг бид нар харах юм татвараар энийг зохицуулахын тулд хөдөлмөрлөж байгаа хүмүүсээ татварын дарамтаар дарамтлах гэхээсээ илүүтэй баялаг хөдөлмөрлөхгүйгээр олж байгаа энэ хэсэг дээрээ татвараа яаж зөв зохистой тавих вэ гэдэг дээрээ анхаарах ёстой байгаад байгаа юм.

Тэгээд нийслэлд ажиллаж байхад энэ хотын төвд байгаа том үл хөдлөхийн объектууд маш бага үнээр бүртгэгдчихсэн байдаг. Хангай зочид буудал гэхэд 600 сая төгрөгийн үнэтэй тиймээ гэж бүртгэгдсэн мөртөө 10 хэдэн жилийн турш нэг ч татвар төлж байгаагүй. УИД-ийн ард байдаг Мандухай зочид буудал гээд 3 давхар том маш гоё объект байдаг тиймээ зочид буудал. Хотын төвд 14 сая төгрөгийн үнэлгээтэй гэж байгаа. Тэгээд жилд тэрийгээ 2 хувиар татвар төлдөг. Юун хажууд нь бид нарын хөдөлмөрлөж байгаа энгийн хөдөлмөрлөж байгаа хүмүүсийн татвар хамаагүй өндөр байгаад байгаа. Тэгээд энэ мэтчилэн гажуудлыг ер нь засах ёстой. Тэгээд энийг яах вэ боловсронгуй шийдэл бас хайж олох ёстой. Гаднын улсын туршлагуудыг харахаар дундын ийм нөгөө үнийг нь верифай буюу тиймээ дундаж маркет үнийг нь гаргаж ирэх ийм механизм л оруулдаг юм байна лээ л дээ. Тэрэн дээрээ хамгийн их сайн ашигладаг нь нотариат. Нотариатаар үл хөдлөхийн шилжих өмчлөлийг шилжих энэ гэрээг хийж байгаа.

Манайд бол зөвхөн нотариат зүгээр нэг гэрээн дээр тамгаа дараад ингээд л явуулдаг байгаа гаднын улсуудад яг энэ гэрээний дагуу тэр юу гэдэг юм 50 саяар байна уу, 60 саяар төлсөн бол тэр нь нотариатын өөрийнх нь байдаг эскро аккаунтаар буюу дундын ийм дансаар шилжиж гүйдэг. Ингэж байж нөгөө нотариатч маань энэ 2 хүн яг хоорондоо үл хөдлөх хөрөнгөө 50 саяар худалджээ. Цаана нь 250 сая биш 50 сая аа гэдгийг өөрөө баталдаг. Нотариатч нэгэнт тангараг өргөсөн өөрөө тусгай зөвшөөрөлтэй этгээд учраас энэ дээр худал буруу мэдээлэл худал буруу гэрээ хэлцэл батлах юм бол маш том хуулийн хариуцлага хүлээдэг. Ийм маягаар дундын ийм этгээдээр үнийн энэ баримжаа зөв үнийг ингээд гаргадаг ийм механизмууд байгаа юм.

Тэгэхээр энийг бас цаашдаа судлаад, манай Сангийн яам татварын бодлогынхон ч гэсэн энэ дээрээ бас сайн ярьж судлах хэрэгтэй байх. Тэгэхгүй бол бид нарын нөгөө нийгмийн шударга ёс буюу хөдөлмөрлөж хөдөлмөрлөөд баахан татвар төлдөг нэг хэсэг, үгүйгээр ингээд зугтаад явдаг нэг хэсэг шударга бус

байдлыг засаж чадахгүй байгаа юмаа гэж байгаа юм. Тэгэхээр яах вэ энэ Цэцийн шийдвэрийг бол хүлээж авах ёстой гэсэн ийм байр суурь илэрхийлж байна аа.

ҮХЦ-ийн дүгнэлттэй холбогдуулан гишүүд үг хэлж, итгэмжилсэн төлөөлөгч Баасанжаргал гишүүн үг хэлье.

Х.Баасанжаргал: Энэ дээр 1, 2 юмыг бас нэг тодруулж хэлж хэдүүлээ ярилцах ёстой болж байгаа нэг юм байгаа. Юу гэвэл мэдээж нөгөө эд хөрөнгөө чөлөөтэй захиран зарцуулах, өмчлөх эрхийн асуудал хөндөгдөнө. Гэхдээ өмчлөх эрх чинь өөрөө туйлын эрх биш тодорхой нөхцөл тодорхой тохиолдлууд дээр бас хязгаарлагдах, хууль тогтоомжоор зохицуулагдах ёстой ийм эрх байгаад байгаа нэгдүгээрт хэдүүлээ тэрийг бас зайлшгүй харах ёстой.

Хоёрдугаарт гэвэл энэ нөгөө Цэцийн дүгнэлт гарахтай холбоотой ҮХЦ-ээ шинжээч томилсон юм. Тэгээд шинжээч томилоод яг ийм ижил төстэй энэ зохицуулалтуудыг бусад улс орнууд хэрхэн зохицуулж ирж байна. Манай улсын энэ зохицуулж байгаа байдал нь ямар байна гэдэг дээр шинжээчийн дүгнэлт гарсан. Тэгээд шинжээчийн дүгнэлт дээр үнэ яах вэ хэд хэдэн улс орнуудынхыг харьцуулаад дээр нь мэдээж Герман ч гэдэг юм уу өөр бас социалист ийм юунуудын орнуудын бас иргэний, манайхтай төстэй иргэний хууль тогтоомжийн системчлэлтэй орнуудынхыг бас танилцуулсан байсан. Тэгээд манай яг энэ зохицуулалт ганцхан зохицуулалтаар зохицуулах гэж оролдож байгаа нь өөрөө болохгүй байна аа. Энэ чинь өөрөө цаашаа ингээд дахиад ийм 2, 3 зохицуулалт ийм бүтэн ийм механизмаа бид нар бүтэн томоор нь хараагүй байна гэдэг дүгнэлт шинжээч дүгнэлт дээрээ дурдсан байгаа юм.

Тэгэхээр хэдүүлээ энэ Цэцийн дүгнэлтийг хүлээж аваад, дахиад энэ заалтан дээрээ ажиллаад, илүү нөгөө сайжруулаад оруулж ирэх нь зөв болов уу гэж харж байгаа. Огт хүчингүй болгоод бас орхиж болохгүй тиймээ. Огт хүчингүй болгоод орхиж болохгүй. Нэг зүйлийг бид нар бодох хэрэгтэй. Уянгахишиг гишүүн сая хэллээ, бас Номинчимэг гишүүн сая хэллээ. Мэдээж юмны үнэ хямдарч болно. Тэгэхдээ хямдарсан тохиолдолд яах вэ гэдэг зохицуулалт нь энэ хууль дээр байгаа байхгүй юу. Үнэхээр хямдарч байгаа бол тэрийг үл хөдлөх хөрөнгийн үнэлгээгээр нь хийлгээд тэр үнэлгээнийх нь дүгнэлтийг үндэслээд бүртгэл өөрөө бүртгэж авъя гэж байгаа. Үнэлгээ хийлгэх бол өөрөө тийм төвөгтэй биш 1-3 хоногийн дотор хийж байгаа. Нэг ойролцоогоор нэг 100-300 мянган төгрөгийн хооронд үнэлгээг хийж байгаа юм байна лээ. Би Цэцэд орохоосоо өмнө энийг бүгдийг нь судалж орсон байгаа.

Тэгээд энэнээс манайхан бүгд ингээд зугтаагаад ингээд зайлсхийгээд байгаа байхгүй юу. Үнэлгээ хийлгэмээргүй байна гээд. Тэгэхээр гэтэл нөгөө Иргэний хууль дээр байгаа нэг заалт байгаа. Бүртгэл үнэн зөв байх ёстой гэдэг заалт байгаа. Тэр чинь ерөөсөө амилахгүй байгаа. Тэгэхээр нөгөө бүртгэл үнэн зөв биш болохоор бүртгэл дээр байгаа мэдээлэлд хүмүүст итгэж энэ эдийн засгийн харилцаа иргэний эдийн засаг чинь ерөөсөө хөгжихгүй байгаа гэсэн үг. Миний үл хөдлөх хөрөнгө тэд юм аа. Ерөөсөө бүртгэлийн мэдээлэл үнэн зөв байх гэдэг итгэл үнэмшил ерөөсөө огт байхгүй болчихсон шүү дээ тиймээ. Тэгэхлээр энэ итгэл үнэмшил өөрөө аягүй чухал. Өөрөө нөгөө энэ үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн хөгжилд аягүй чухал суурь үзүүлэлт нь юм байна лээ. Бүртгэлийн үнэн зөв байдал нь өөрөө. Гэтэл тэрийгээ бид нар ингээд нэг ийм өнөө маргаашийн ийм асуудалтай ингэж хараад ингээд энийгээ бид нар энэ бүртгэлийг хөгжүүлэх талаас нь ерөөсөө бодохгүй

байгаа гэсэн үг. Тэгэхээр энийг жаахан ийм том дүр зургаар нь хэдүүлээ хараад, тэгээд энэ заалтыг илүү сайжруулах, илүү нарийвчлах зохицуулалтыг илүү оновчтой болгох талаас нь манай Байнгын хороо би бол ажиллах ёстой гэж харж байгаа.

О.Номинчимэг: Одонтуяа гишүүн үгүй юу. Тэгвэл хүлээж аваад энийг цаашид сайжруулах талаар ер нь Байнгын хороо анхаарч, ажлын хэсэг гаргаж ажиллая гээд. Үг хэлж дууслаа. Санал хураалт явна. Гишүүд санал хураалтад бэлдэнэ үү.

Энэ хэлэлцэж байгаа зүйл заалт бол Үндсэн хуулийн 4, 3 одоо зарчмыг, заалтыг зөрчсөн гэж үзэж байгаа учраас 3 саналын томьёоллоор санал хураах юм байна.

1 дүгээр санал хураалт. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 9.1.3, 9.1.4-т заасан үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн үнээс бууруулж бүртгэхгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

73.3 хувь дэмжсэн байна.

2.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 9.1.3, 9.1.4-д заасан үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн үнээс бууруулж болохгүй, бүртгэхгүй гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

62.5 хувиар дэмжигдлээ.

3.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 9.1.3, 9.1.4-д заасан үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн үнээс бууруулж бүртгэхгүй гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь заалтад үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, өмчлөх эрхтэй гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

62.5 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын ҮХЦ-ийн 2025 оны 6 дугаар дүгнэлтийг хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын ҮХЦ-ийн 2025 оны 6 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал танилцуулна.

Дараагийн асуудалд оръё. 4 дүгээр асуудал. [Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь өөр хоорондоо эсхүл бусад хуультай зөрчсөн талаарх хууль зүйн дүгнэлтийг хэлэлцэнэ.](#)

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон холбогдох бусад хуулийн төслийн талаар Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас 2025 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 2025-10 тоот хууль зүйн дүгнэлт гаргасныг та бүхэнд тараасан байгаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ариунхур дарга оролцож байна.

Хууль зүйн дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ариунхур дарга танилцуулна. 1 дүгээр микрофоныг өгье.

Ч.Ариунхур: Хууль зүйн байнгын хорооны хуралдаан даргалагч болон гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Хууль зүйн дүгнэлтийг танилцуулъя аа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн нэгтгэсэн төслүүдийн зүйл, хэсэг, заалт өөр хоорондоо болон бусад хуультай зөрчилдсөн эсэх талаар хууль зүйн дүгнэлт гаргуулахаар ажлын хэсгээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.2 дахь заалтыг үндэслэн энэхүү дүгнэлтийг гаргалаа.

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаар.

Төслөөр 1.Төслөөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 69.1 дэх хэсгийг өөрчлөн найруулж, төсвийн төслийг хэлэлцэн батлах үе шат 4 байсныг 5 болгон нэмэгдүүлэхээр тусгасан тул мөн зүйлийн 69.2 дахь хэсгийн төсвийн төслийн талаар хяналтын сонсгол явуулах хугацааны талаарх зохицуулалтыг.

2.Төслөөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64.1 дэх хэсгийг өөрчлөн найруулж, төсвийн хүрээний мэдэгдлийг 4 үе шаттай хэлэлцэхэд хэлэлцэн батлахаар тусгасан тул мөн зүйлийн 64.2 дахь хэсгийг.

3.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 21, 23, 24 дүгээр зүйлийн зүйлд заасан төсвийн төслийн хэлэлцэх үе шатны зохицуулалтыг.

4.Төсөлд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.13 дахь хэсгийг бүхэлд нь хүчингүй болгохоор тусгасантай холбоотой мөн зүйлийн 71.9 дэх хэсгийн эшлэлийг тус тус нийцүүлэх.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаар.

1.Төслөөр төсвийн төслийн боловсруулалтын хэлэлцүүлгийн явцад болон төсвийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, санал, дүгнэлт гаргах чиг үүргийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд гүйцэтгэхээр Тогтвортой байдлын зөвлөл

гүйцэтгэхээр тусгасантай холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22.2, 22.5 дахь хэсгийн заалтыг.

2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтад Ерөнхий сайдын мэдээллийг Улсын Их Хурлын асуулгын цаг болгон өөрчлөхөөр болсонтой холбогдуулан Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийг тус тус нийцүүлэх шаардлагатай байна.

3.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалтын Хууль сахиулах ажиллагааны Тусгай хяналтын дэд хороог байгуулах мөн зүйлийн 7 дахь заалтын тус дэд хорооны эрхлэх асуудлын талаарх заалтын хэрэгжих хугацаа өөрчлөх тохиолдолд Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн дагаж мөрдөх 2 дугаар зүйл буюу дагаж мөрдөх хугацааг мөн уялдуулан өөрчлөх шаардлагатай болно оо.

Санал, дүгнэлт. Хууль хоорондын нийцэл болон хууль зүйн техникийн шаардлагыг хангах үүднээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай төслийн зарим заалтыг түүнчлэн хууль хоорондын уялдааг хангах үүднээс Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн дагаж мөрдөх хугацааг өөрчлөх томъёоллыг холбогдох төслүүдэд нэмж тусгахыг зөвлөж байна аа.

Энэ дүгнэлтийг үндэслэл болгож гаргасан заалт нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд холбогдох Байнгын хороо буюу ТББХ эцсийн хэлэлцүүлэг явуулахдаа дараах тохиолдолд санал хураалт явуулж болно гээд анх 42.2.2 анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй санал болон хуулийн төслийн зүйл, заалт, хэсэг заалт өөр хоорондоо эсвэл бусад хуультай зөрчилдсөн талаарх хууль зүйн дүгнэлтийг ХЗБХ дэмжсэн нөхцөлд ТББХ энэ асуудлаар зарчмын зөрүүтэй санал хураалгах боломжтой болох юмаа. Баярлалаа.

О.Номинчимэг: Ариунхур даргад баярлалаа. Хууль зүйн дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Асуулт, үг хамтдаа явчихъя алга байна. Алга байна. Санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдье.

Хуулийн төслийн зүйл, хэсэг заалт нь өөр хоорондоо эсхүл бусад хуультай зөрчилдсөн талаарх Улсын Их Хурлын Тамгын газрын 2025 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн тоот 2025 чирээс 10 тоот хууль зүйн дүгнэлтийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт 62.5 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн асуудал буюу сүүлийн асуудал 5 дугаар асуудал. 5 дугаар асуудлыг бусад гэсэн байдлаар тов дараалалд оруулсан. Энэ хүрээнд Баттөмөрийн Энхбаяр гишүүний саналыг үндэслэн Байнгын хорооны тогтоол буюу Ажлын хэсэг байгуулах тухай тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа.

Энэ тогтоолын ажлын хэсэг хууль боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Алга байна.

Тэгвэл тогтоолын төслийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураая. Санал хураалтдаа бэлдье.

Ажлын хэсэг байгуулах тухай Хууль зүйн байнгын хорооны тогтоолын төслийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

62.5 хувиар санал дэмжигдлээ. Байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье. Ажил хэрэгчээр хуралдаандаа суусан гишүүддээ баярлалаа.

12.25 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА